

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2022 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР /МЯГМАР
ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

№	Баримтын агуулга	Хуудасны дугаар
1	Хуралдааны товч тэмдэглэл	1-5
2	Дэлгэрэнгүй тэмдэглэл	6-60
	1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2022.0.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	6-13
	2.Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээр (“Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл-II үе шат”)-ийн төсөл /Засгийн газар 2022.03.23-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/	13-28
	3.Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр төслийн бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төсөл /Засгийн газар 2022.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ/	28-60

ХУРААНГУЙ ТЭМДЭГЛЭЛ

Гурав.Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр төрлийн бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төсөл /Засгийн газар 2022.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Б.Анхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Монголбанкны ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, мөн банкны Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа, Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал А.Энхжин нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Ц.Батбаатар, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан референт Г.Нарантуяа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр төрлийн бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

1.Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр төрлийн бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан хариулж, тайлбар хийв.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нар хариулж, тайлбар хийв.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Х.Булгантуяа, Б.Пүрэвдорж нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан хариулж, тайлбар хийв.

Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ж.Батжаргал, Д.Өнөрболор нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Монголбанкны ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн нар хариулж, тайлбар хийв.

Төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Г.Тэмүүлэн нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан хариулж, тайлбар хийв.

Төслийн 9 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагийн тавьсан асуултад Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон хариулж, тайлбар хийв.

Төслийн 6, 8, 10, 11 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

2.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Хүрэлбаатарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан хариулж, тайлбар хийв.

Төслийн 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

3. “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл:

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Тогтоолын төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Хүрэлбаатар чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 03 минут үргэлжилж, 19 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 73.7 хувийн ирцтэйгээр 18 цаг 28 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ч.ХҮРЭЛБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр, төрлийн бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийж эхэлье ээ.

Ажлын хэсгийг бол Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулсан. Ажлын хэсэг нэлээд ажиллаад санал хураахад зориулаад хэд хэдэн саналын томъёолол бэлдчихсэн байгаа юм. Тэгээд бид нар энэ гарсан санал, дүгнэлтийг Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлэх учраас одоо бэлдчихсэн байгаа тэр саналын томъёоллоор санал хураах, Төсвийн байнгын хороон дээр санал хураах бол илүү л болгох гээд байгаа юм. Тийм. Яагаад гэвэл тэнд очоод бас санал хураана шүү дээ. Дахиад л санал хураах юм. Зүгээр та бүгдэд бол саналтай холбоотой зүйлүүдийг бас танилцуулж болно одоо. Ийм ийм өөрчлөлтүүдийг бол танилцуулсан гэдгийг хэлж болно. Нэгэнт нэг ажлыг бас хоёр хиймээргүй байгаа юм. Гэхдээ одоо Төсвийн байнгын хороо дээр гишүүд асуулт асууж, үг хэлэх нь бол одоо нээлттэй байгаа гэдгийг би эхлээд танилцуулъя аа.

Ажлын хэсгийг танилцуулъя.

Сангийн сайд Жавхлан, Гадаад харилцааны сайд чинь юу хийж байгаа билээ. Одоо Төсвийн байнгын хороо дээр ийм их олон сайд ороод ирэхээр чинь бас гайхаж байна шүү дээ. Ер нь сайд нарыг оролцуулдаггүй ганцхан Сангийн сайдтай хамаг ажлаа ярьчихдаг. Гэхдээ бол сайд нар хүрэлцэн ирсэнд их баярлаж байна, уншина аа одоо. Гадаад харилцааны сайд Батцэцэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Мэндсайхан, Эрүүл мэндийн сайд Ёндон, уучлаарай. Эрүүл мэндийн сайд Энхболд, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ганбат байна. Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга Энхболд байна. Монголбанкны Ерөнхийлөгч Лхагвасүрэн байна. Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал Баярдаваа байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны газрын дарга Болорчулуун байна. Монголбанкны Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал Энхжин байна. Тэлмүүн байна. Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Тэлмүүн байна аа. Дээр нь Анхбаяр байна. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга байна аа.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оролцъё.

Хууль, тогтоолын төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж эхлэх. Тэгэхдээ ингээд энэ олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр, төрлийн бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл бол 11 зүйлтэй байгаа. Тухайн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас болон бусад оролцогчоос асуулт асууж болно.

Хуулийн төслийн нэгдүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу? Байхгүй байна.

Пүрэвдорж гишүүн, яг онож асуумаар байна. Хэдүүлээ, одоо жоохон пропорционал Байнгын хороо шиг байя. Пүрэвдорж гишүүн нэг дүгээр зүйлтэй холбоотой.

Б.Пүрэвдорж: 2012-16 онд үнэ тогтворжуулах хөтөлбөрийн дагуу бас гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг тогтворжуулсан эргэлтийн хөрөнгийг аж ахуйн нэгжүүдэд олгосон. Энэ хүрээндээ бас энэ 16 оноос хойших энэ эдийн засгийн нэлээн өсөлтүүдийг бий болгоход энэ компаниудыг дэмжсэний үр дүнд бий болсон гэж үздэг.

Тийм ч учраас татварын орлого болон бусад орлогууд бол нэлээн өндөр түвшинд очсон, дээрээс нь бол валютын нөөц их хэмжээгээр нэмэгдсэн. Хэдийгээр одоо уул уурхайн бүтээгдэхүүний үнэ өссөн, экспорт нэмэгдсэнтэй холбоотой ч гэсэн бас тодорхой хэмжээгээр энэ бараа бүтээгдэхүүнийг экспортыг дэмжсэн, импортыг орлосон аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг дэмжсэний үр дүнд бий болсон гэж үздэг. Энэ үнэ тогтворжуулах хөтөлбөрийг бол маш их улс төржүүлсний үр дүнд 2016 оны сонгуулийг та бүхэн ялалт байгуулсан гэж ойлгож байгаа. Тийм учраас өнөөдрийн энэ оруулж ирж байгаа энэ хууль бол энэ үнэ тогтворжуулах хөтөлбөрийн нэг хувилбар юм аа. Тийм учраас та бүхэн эндээ энэ хуулийг хэдийгээр олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нарийн төрлийн бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт хомсдолоос сэргийлэх сөрөг нөлөөллийг бууруулах гэж нэлээн юуг нь нэрийг нь урт болгож байгаа болохоос биш яг үнэ тогтворжуулах хөтөлбөртэй адилхан гэж би үзэж байгаа. Тэгэхээр тухайн үед одоо үнэ тогтворжуулах хөтөлбөрийг Байнгын хороо, Эдийн засгийн байнгын хорооны тогтоолын дагуу хэрэгжүүлээд явсан. Тэгэхээр өнөөдрийн энэ хууль болгож орж ирж байгаа нь зөв гэж би үзэж байгаа.

Тийм учраас энэ хуулийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээ чинь үнэ тогтворжуулах хөтөлбөр мөн үү гэдгийг асууя.

Ч.Хүрэлбаатар: Жавхлан сайд хариулах уу? Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Пүрэвдорж гишүүн ээ, 10 жилийн өмнө төрсөн хүүхэд одоо 10 нас хүрчихсэн явж байна. Өнөөдөр төрсөн хүүхэд чинь 10 жилийн өмнө төрсөн хүүхэд энэ мөн үү хэл гээд надад тийм л адилхан сонсогдоод байгаа юм. Одоо хямралт нөхцөл байдал үүсэж байгаа хүндрэл нөхцөл байдал болбол адилхан шүү дээ. Өнөөдөр өсөж байгаа эдийн засгийн нөхцөл хүндрэл 10 жилийн өмнөх 10 жилийн дараа гаргах тэгээд ийм шокийн эсрэг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд үндсэндээ том агуулгаараа бол бүгд л ойролцоо байдаг. Энэ дээр шинэ дугуй зохиогоод цоо шинэ одоо онол гаргаж ирээд ингээд ухаанаа уралдуулаад байх шаардлага нэг их байхгүй. Гол нь тухайн үеийн эдийн засгийн хүндрэл тэр шок юунаас үүсэв, оношоо зөв тавиад зөв эмчилгээ хэрэглэх зөв одоо арга хэмжээ авах л ийм л шаардлагатай юм байгаа юм.

Тэгээд хууль оруулж ирж байгааг дэмжиж байгаад одоо талархалтай байна. Тэгээд ер нь бол ингээд хуульчлаад хэн хэн ямар үүрэг, эрхтэй оролцох вэ гэдгээ маш тодорхой болгочих нь одоо хожим маань гарч болох бас уршгаас өнөөдөр бас энэ ажилд оролцох төрийн албан хаагч нар институцууд мөн одоо нийгмийн хариуцлагаараа оролцох хувийн хэвшлийнхэн ч гэсэн дээ одоо энэ дээр итгэл үнэмшилтэй ингээд хуулийн хүрээндээ ажиллаад зохион байгуулаад явах нь илүү сайн үр дүн гарна аа гэж ингэж харж байгаа.

Тийм, нэрэн дээрээ ч маш ойлгомжтой байгаа шүү дээ. Шалтгааныг нь заачхаж байгаа юм. Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүсэлтэй гээд. Тэгээд гол нэр төрлийн бараа бүтээгдэхүүн гэдэг дээрээ ер нь нэг 3 асуудал дээр л төвлөрье шатахуун, мах, гурил гээд, тэгээд өөр чадахгүй зүйлүүдийг бол өндөр эрсдэл аваад ингэж явах нь болбол үр дүнгүй ээ, ажил саармагжина, муу үр дүн гарна аа. Олигтой юм болохгүй ээ гээд энэ 3 дээрээ төвлөрье гэж байгаа. Тэгээд энэ үнийн одоо өсөлт савлагаанаас урьдчилан сэргийлж сөрөг нөлөөллүүдийг нь бууруулах ийм одоо хууль болгож оруулж ирж байгаа.

Ч.Хүрэлбаатар: 1 дүгээр зүйлтэй холбогдуулаад асуух, биш ээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Пүүжээ ажлын хэсгийн гишүүн шүү дээ. Пүрэвдорж гишүүн үг ээ хэл хэл, Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр Жавхлан сайдын тайлбарт нэг зүйл алдаатай байна. Өөрөөр хэлбэл 2012-16 оны үед чинь зэс 5 мянган доллар байсан, нүүрс 30-хан доллароор зардаг байлаа. Алт 1200 долларын үнэтэй байсан. Гэтэл өнөөдөр зэс 11 мянган доллар, 10 мянга даваад явчихсан, нүүрс 460 доллар байна. Алт 2000 долларт 30 доллар дутуу байна. Ийм өндөр үнийн өсөлттэй байж байхад энэ хилийнхээ боомтынхоо үйл ажиллагааг энэ хариуцлага энэ тэрээ сайн шийдээгүй энэ зүйлийг олон улсын хямралт байдал л гэдэг рүү оруулж тайлбар хийгээд, түүн дотроо тэр 12-16 оны үед энэ уул уурхайн бүтээгдэхүүн хэт бага үнэтэй байсан тэр эдийн засгийг удирдаж явсан тэр Ардчилсан намынхантай одоо хүртэл барьцаж байгаа чинь бас харамсаж байна аа гэдгийг хэлье.

Ч.Хүрэлбаатар: Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Би бол улс төржүүлж хэлээгүй шүү. Та харин улс төржүүлээ, хэрвээ тэгж одоо улс төржүүлнэ гэх юм бол нэрээ бүр ингээд сольчих л доо. Сүүлийн 10 жил боломжтой бид гаргах ёстой потенциалын нийт экспортоо төмөр замаа барьж чадаагүй. Хилийн солбицлынхоо асуудлуудыг шийдэж чадаагүй учраас өнөөдөр хүнд нөхцөл байдалд ороод ингээд экспортууд ийм гарч чадахгүй байгаа улмаас хангалттай нөөц бүрдүүлж энэ олон жил чадаагүйн улмаас ийм хүндрэлтэй байдлуудаас гарах ийм байдалд гарцаагүй орчихсон байна аа гэдгийг нь тэгээд оруулаад явчихъя л даа.

Ч.Хүрэлбаатар: Хариуллаа, хариулт дууслаа.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу?

Кнопоо дар. Пүрэвдорж гишүүн, юу чинь орохгүй байна шүү дээ. Өөр өөрөөсөө асуух юм уу? Өнөрболор гишүүн асуулт асууя аа.

Д.Өнөрболор: Үндсэндээ хуулийн төслийг бол дэмжиж байна аа. Гэхдээ бид нар бас нэг дотооддоо энэ инфляцын нийт тоон дүнд анхаарахаасаа илүүтэй бид нар энэ шалтгааныг саармагжуулах яг гол нэр төрлийн барааны үнийн өсөлтийг хэсэгчлэн онилох нь бол би чухал байна аа гэж хараад байна л даа. Статистикийн тоо баримтаас ингээд харах юм болбол инфляцын 50,9 хувийг импортын барааны өсөлт эзэлж байгаа гэдэг энэ болбол гол шалтгаан байгаад байгаа юм. Тэгэхээр энэ өөрөө онош нь гэсэн үг. Тэгэхээр энэ гаалийн гацаа хүндрэлийг одоо энэ хүндрэлийг хаана юундаа байгаа юм бэ? үүнийг яаралтай шийдэх асуудал байгаад байна аа гэж харагдаж байна.

Нөгөө нэг асуулт нь импортын урсгалыг саадгүй болгох шаардлагатай асуудал гарч ирж байна л даа. Тэгэхээр энэ салбарын яамд, сайд нар болбол бас одоо

тодорхой түвшинд ажлаа хий гэсэн үг гэж бол ойлгож байна. Ер нь бараагаа хил гаалиар ингээд оруулахын тулд цаад талаасаа Хятад талаасаа энэ сугалаагаар бараагаа татаж оруулж ирж байна аа гэдэг чинь энэ одоо юу гэсэн үг вэ? Энэ одоо тусгаар улсын эдийн засгийн аюулгүй байдал алдагдаж байна аа гэсэн асуудал биш үү? Энэ дээр аа Батцэцэг сайд аа, би хариулт авмаар байна аа.

Нөгөөтээгүүр энэ импортын хэрэгцээгээ ер нь өөрсдөө хангадаг болоход энэ бодлогоо чиглүүлмээр байна аа, Жавхлан сайд аа.

Нөгөө нэг асуудал нь болбол энэ үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн үзэл баримтлалд энэ газрын тосны үнийн одоо хэт хэлбэлзэлд өртөх эрсдэлээс сэргийлж, улсын нөөцийн түүхий эдийг нефтиэр 6 сараас доошгүй хэмжээнд одоо байлгана аа гэж заасан байдаг. Тэгэхээр энэ одоо хэр зэрэг хэрэгжиж байгаа вэ? энэ заалт.

Ч.Хүрэлбаатар: Батцэцэг сайд, дараа нь Ёндон сайд хариулъя аа.

Б.Батцэцэг: Өнөрболор гишүүний асуултад хариулъя аа. Монгол Улсын Засгийн газар, Хятадын Засгийн газартай байнгын харилцаа холбоотой маш өндөр түвшинд яриа хэлэлцээр явагдаж байгаа. Хамгийн сүүлийн жишээ уржигдар би Ван и сайдтай Гадаад хэргийн сайдтай бас хоёр цаг шахуу цаг гучин минут, бас бүх хил, гааль боомттой асуудлуудаа нягталж ярьсан. Ерөнхийлөгч нарын утсаар ярьсан, Ерөнхий сайдын айлчлалын мөрөөр Гадаад харилцааны сайдын айлчлалын мөрөөр хийгдэх ажлууд бол явагдаж байгаа. БНХАУ бол хуурай замын боомттой 12 улстай, нийтдээ 100 гаруй боомтуудынх нь 50 хүрэхгүй хувь нь ажиллаж байгаа. Ганцхан одоо Монгол Улс дээр боомтуудын тал нь ажиллахгүй байгаа юм биш. Хил гааль, хаагдаагүй гол экспортын бараанууд бол явагдаж байгаа. Гол нь ковидын өмнөх хэмжээндээ очуулъя, хоногт бид нар дор хаяж 1000 нүүрс тээврийн хэрэгсэл гаргамаар байна аа гэдэг ийм тодорхой саналуудыг ярьж байгаа.

Манайд Хятадын зүгээс тавигдсан зарим шаардлагуудыг бол бид нар тодорхой хэмжээнд биелүүлсэн гэж үзэж байгаагаа хэлээд одоо энэ экспортоо нэмэгдүүлье чухал байгаагаа бол байнга тайлбарлаж байгаа. Тэгэхээр Хятад улс маань болбол танайд бид нар илүү боломжийг олгож байгаа. Бусад хил залгаа улсуудтай болбол нөхцөл байдал танайхаас хамаагүй одоо доогуур байгаа. Жишээлбэл, Казакстан руу өдөрт 200 хүрэхгүй тээврийн хэрэгсэл гаргаж байгаа. Мьянмар луу 60 тээврийн хэрэгсэл тэгэхэд Монгол руу 500-600 болсон. 2 сарын өмнө 200-аад тээврийн хэрэгсэл явж байсан аажуухан нэмэгдэж байгаа. Монгол Улсад тавьж байгаа шаардлагууд нь болбол хилийн орчимд боомт дээрээ халдвар хамгааллын дэглэмээ ягштал баримтлах түүнийг бол тийм бас хангалттай гэж үзэхгүй байгаа. Тийм учраас лабораториуд бас бид нарт хандивлаж байгаа, лабораториудаа суурилуулаад халдвар хамгааллын дэглэмээ сайжруул аа гэдэг ийм зөвлөмжийг бол дахиад өгсөн.

Боомтуудын сэргэлт дээр бол дахин хэлэхэд бол давуу талуудыг олгоод хэдийгээр ковидтой, одоо өчигдөр уржигдар ч гэсэн он гарснаас хойш 42 ковидын тохиолдол гарсан. Гарсан хэдий ч бид нар танайхыг бол оруулж байгаа шүү гэдгээ хэлж байгаа, тийм. Тэгээд бусад улсуудтай ийм байгаа гэдгийг тайлбарласан. Тэгэхдээ бас энэ хилийн зарим боомтоор зорчигч тээврийн хөдөлгөөнийг сэргээх тухай асуудлыг Хятадын Гадаад харилцааны яам шийдээд 4 сарын 01-нээр шийдвэр нь гаргаад ногоон гарцын журмаа хэрэгжүүлээд үйлдвэрийн ажилтнууд зайлшгүй явж

байх ёстой инженер техникийн ажилтнууд, зайлшгүй орж гарах ийм эхний ээлжид албан улсуудаа болбол явуулъя гэдэг шийдвэрээ гаргачихсан.

Хилийн зарим боомтын ачаа тээврийн хөдөлгөөнийг сэргээх тухайгаа хэлсэн. Бургастай боомтыг нь 04 сарын 15 дээр, мөн Шивээхүрэн-Сэхээ боомт дээр бас одоо энэ сардаа багтааж нээнэ ээ гэж хэлсэн байгаа. Тэгэхээр нийтдээ энэ хоёртойгоо нийлээд 6 боомт ингээд ажиллана гэсэн үг. Энэ дээрээ бас халдвар хамгааллаа сайн нэгдүгээрт баримтлах ёстой, хоёрдугаарт ковидын энэ үеэр болбол Хятадын Гадаад харилцааны яам боомтуудынхаа дэд бүтцийг сайжруулах, халдвар хамгааллын дэглэмээ сайжруулах, лабораториуд байгуулах, бүтээн байгуулалтууд хийх, засвар үйлчилгээ хийх ажлыг ингээд цогцоор нь арга хэмжээ авсан юм байна лээ. Тэгэхээр одоо Бургастай Сэхээ боомт дээр болбол энэ дэд бүтцийнх нь засварын ажлууд нь дуусчихсан. Одоо ингээд мэргэжлийн хяналт нь хүлээж аваад ашиглалтад оруулж байгаа гэдгээ бол хэлсэн.

Ингээд 2 талаасаа энэ Ерөнхий сайдын айлчлалаар ярьсан төмөр замын огтлолцлын цэг бусад энэ компани хоорондын хамтын ажиллагаа, хилийн боомт, төмөр замтай холбоотой явж байгаа бүтээн байгуулалтуудаа Монголын тал одоо сайн хийгээд ингээд явах юм болбол Хятадын талаас бид нар одоо ямар ч юман дээр татгалзах хаах боох тийм юм байхгүй гэдгээ одоо албан ёсоор бүх түвшинд хэлж байгаа гэдгийг хэлье.

Ч.Хүрэлбаатар: Ёндон сайд. Ажлын хэсгийн 2 дугаар микрофон.

Г.Ёндон: Өнөрболор гишүүний асуултад хариулъя аа. Энэ газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн арван наймын гурав гээд заалт байдаг. Үүгээр болохоор л одоо нөөц бол улсын нөөцөөс бүрдэнэ, компанийн нөөцөөс бүрдэнэ гэж байдаг. 2021 оны 10 сарын 16-наас өмнө бол компанийн нөөц бол 30 хоногийн нөөцөөс бүрддэг байсан. Тэгээд одоо бид бүхэн мэдэж байгаа 9 сард бол шатахууны хомсдолын асуудал үүссэнээс хойш бол энд яригдаж байгаад анх бол компаниудын зүгээс бол нэг 3 сарын нөөц бүрдүүлж байя гэж санал гаргаад Ерөнхий сайдын зүгээс одоо Монголбанкны Ерөнхийлөгч, Уул уурхайн сайдад чиглэл өгөөд 3 сарын нөөц бүрдүүлэх энэ эргэлтийн хөрөнгийн эх үүсвэрийг Монголбанкны хөнгөлөлттэй санхүүжилтээр шийдье ээ гэсэн шийдвэр гарсан. Ингээд ярилцаад хэлэлцээд явахаар болохоороо сүүлдээ нөгөө компаниудын зүгээс бол 3 сараар ингэж шатахууны хангахаар нь болохоороо л нөгөө хорогдол одоо янз янзын, зардал нь их болоод хүүтэй мөнгө удаан хугацаагаар ингэж байгаа учраас бол үүнийг 45 хоног байлгая гээд 45 хоног дээрээ шийдээд 2021 оны 10 сарын 16-ны 311 дүгээр тогтоол гарсан. Ингээд компанийн нөөц бол 30 хоног биш, 45 хоног болж нэмэгдсэн. Өнөөдөр бол яг 45 хоногийнхоо нөөцөөр аж ахуйн нэгжүүд Монголбанкнаас хөнгөлөлттэй санхүүжилтийн зээл аваад явж байгаа. Өнөөдрийн байдлаар бол 92 бензин дээр, жишээ нь хэлэхэд бол улсын нөөц бол 42 хоногийн хэмжээтэй байж байгаа.

Ч.Хүрэлбаатар: Жавхлан сайд.

Б.Жавхлан: Өнөрболор гишүүний асуултад нэмж хариулъя аа. Бид нэлээн ярилцаж ярилцаж яг энэ 3 гол бүтээгдэхүүн дээрээ л тогтсон байгаа юм. Яг стратегийн гэж үзэж энэ 3 дээрээ, ямар ч байсан нэг энэ гуравтайгаа байхад бид давж гарна аа гэж ингэж харж байгаа юм. Тэгээд өөр бүтээгдэхүүнүүд оруулж ирэхээр

бид нар дийлэхгүй, төсөв ч дийлэхгүй өөрөө энэ асуудал нь тарамдаад үр дүнгүй болно оо гэж ингэж харж байгаа юм нэгдүгээрт.

Хоёрдугаарт бид импортын хэт хамааралтай байгаагаасаа салах гэдэг бол маш зөв өө, энэ бол мөнхийн сэдэв. Манай улсын хувьд бол сүүлийн 30 гаруй жилийн сэдэв шүү дээ тийм ээ. Бид нар эндээсээ салахын тулд мөрийн хөтөлбөр, энэ 4 жилийн Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүх төлөвлөгөөнүүд дээрээ энэ ажлыг яг энэ рүү чиглээд экспортуудыг нь дэмжээд импортоо орлох дотоодын үйлдвэрлэл гэсэн, эцсийн эцэст бүх явж байгаа ажил зорилгууд энэ рүүгээ чиглэж очиж байгаа. Ялангуяа Засгийн газрын өргөж барьсан, Их Хурлаас баталсан сэргэлтийн 6 бодлого маань эцсийн дүндээ яг энэ рүү л чиглэж очно. Эрчим хүчний хязгаарлалтаас гаръя, боомтын сэргэлтээ хийе, аж үйлдвэрийнхээ сэргэлтийг хийе ээ. Энэ бүх бодлогууд маань энэ рүүгээ ингээд чиглэнэ ээ. Гэхдээ ялгаа нь болбол энэ хуулиар бол маш богино хугацааны үр дүн гаргах богино хугацааны шокноос одоо хохирол багатай эдийн засаг дээрээ гэмтэл багатайгаар гаръя аа гэдэг ийм зорилгоор энэ хуулийг өргөн барьсан. Дунд хугацаандаа бол саяын таны тавьж байгаа асуудал бол маш зөв. Энэ дээр бол бусад мөрийн хөтөлбөр, Засгийн газрын үйл ажиллагаа, чиглэл тэр бүх зүйл ийшээгээ чиглэж байгаа. Баярлалаа.

Ч.Хүрэлбаатар: Сандаг-Очир гишүүн асуулт асууя.

Ц.Сандаг-Очир: Сангийн сайд харин миний асуух гэж байсныг л асуучихлаа, хариулчихлаа л даа. Би бол яг энэ гурвын хоёрын нэг, гурвын хоёрын хоёр, гурав гээд мах, гурил, газрын тос дээр нэмээд эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүн, эм тарианы асуудлаа оруулж ирэхгүй байсан юм уу гэж асууж байна. Яагаад гэхээр өчигдөрхөн бас бүлгийн хурал дээр гишүүд бол нэлээн олон гишүүдээс бас энэ эм, эм тарианы асуудал бас хүнд байгаа гэдгийг ярьж байгаа юм. Өнөөдөр ч Нийгмийн бодлогын байнгын хороон дээр олон гишүүд бас энэ асуудлаар ярьж хөндөж байгаа. Сангийн сайдын зүгээс бол энэ гишүүдээс гарч байгаа энэ саналыг Засгийн газар дээр яаж авч үзсэн бэ? Эм тарианы асуудал бол ард иргэдийн эрүүл мэнд, амь насны асуудал. Тэгээд энэ 3 гол нэр төрлийн бараа бүтээгдэхүүн бол одоо стратегийн гол бүтээгдэхүүнээ л анхаарч байна. Бусад нь бол одоо тэгээд чадахгүй нь ээ, зах зээлийнхээ горимоор яв аа гэж. Гэтэл эм тарианы асуудал хомсдол үүсвэл яах вэ. Нөөц ямар байгаа вэ?

Зарим гишүүд ярьж байна аа. Эхнээсээ эмнэлгүүд дээр эм тарианы хүрэлцээ хангамж байхгүй болсон байна аа. Дутагдалтай болсон байна аа гэж. Тэгээд цаашдаа нөхцөл байдал амаргүй болбол одоо энэ эм тарианы хүрэлцээ хангамжгүй болбол асуудал яаж хүндрэх вэ яг л адилхан мах, гурилтай чинь яг л адилхан. Энэ хавар өвчлөл ямар байлаа, одоо ч хэвээр буураагүй байдалтай байна. Энэ дээр одоо Засгийн газар авч хэлэлцсэн үү? Энэ гишүүдээс гарсан саналыг. 4 дэх болгоод одоо эм тариагаа оруулж ирэхэд ямар хүндрэл байгаа юм, ямар бололцоо боломж нь байгаад байгаа юм. Байхгүй нь юу байгаа юм, хүндрэл нь юу байгаа юм гэдгийг нэг тодруулж хэлж өгөөч. Баярлалаа.

Ч.Хүрэлбаатар: Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Баярлалаа. Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя аа. Засгийн газраар хэлэлцсэн, ярилцсан. Ингээд 3 бүтээгдэхүүнээс нэмээд бүр бид элсэн чихэр,

цагаан будаа, эм, эмнэлгийн хэрэгсэл, ялангуяа дотоодын үйлдвэрлэлийнх нь түүхий эд гэж нэлээн ярьж судалсан юм аа. Тэгээд яг саяын хэлдгээр арилжааны хэлбэрээр ер нь дийлэнх нь орж ирдэг, дийлэнх нь орж ирдэг. Тийм учраас тэр хэсэг дээр бол одоо төр оролцоод явах нь яг өнөөдөр одоо энэ шаардлагатай 3 бүтээгдэхүүнээсээ давсан тийм шаардлага бол биш юм аа. Төр үүрэг хариуцлага аваад явах нэн тэргүүний асуудал нь бол энэ юм аа гэж байгаа юм. Тэгж үзсэн, Их Хуралд ингээд ийм байдлаар өргөн барьсан, Их Хурал дээр хэлэлцээд шийднэ биз дээ гэсэн ийм байдлаар явуулсан байгаа.

Энэ дээр Энхболд сайд бас нэмж хариулаарай. Төр үнэхээр анхааралдаа аваад эм, эмнэлгийн хэрэгслүүд дээр нь онцгой ач холбогдол одоо тухайлан чухал чухал зүйлүүд байдаг юм байдаг. Түүний худалдан авалт, татан авалт нь болбол тэртэй тэргүй төсөвлөөд өгчихсөн ингээд явж байдаг. Мэдээж зохион байгуулалтын арга хэмжээг одоо юу гэдэг юм, энэ хуулиас дагах гарах тогтоолоор ч юм уу, одоо илүү одоо ач холбогдол өгч, зохион байгуулалтын хувьд үүнийг илүү нөөцийг нь хуримтлуулах, худалдан авалтуудыг нь төр өмчлөх хугацаа алдахгүй байх ийм зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг бол Засгийн газар одоо онцгой анхаараад явна аа гэсэн ийм шийдэлтэйгээр оруулж ирсэн байгаа.

Ч.Хүрэлбаатар: Энхболд сайд нэмж хариулах уу? Ажлын хэсгийн 5 дугаар микрофон.

С.Энхболд: Эрхэм Төсвийн байнгын хорооны гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Бид нар Засгийн газрын хуралдаан дээр ярьсан. Энэ асуудлыг бас бид нар нэлээн олон талаас ярьж, ялангуяа энэ 2 жил гаруйн хугацаанд эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх тал дээр бас нэлээн асуудлууд үүсэж байсан. Тухай бүр Засгийн газар бас тодорхой төсвийг төсөвлөж, бас зарим эм, эмнэлгийн хэрэгслийг агаараар татан авах ийм ажлыг бол зохион байгуулж ирсэн. Манай улсын хувьд бол 95 оноос хойш 1995 оноос хойш өнөөг хүртэл бүх эм, эмнэлгийн хэрэгсэл дандаа хувийн хэвшил импортолж оруулж ирдэг. Тэгэхээр манай энэ улсын эмийн бүх импортыг бол энэ хувийн хэвшлийнхэн хариуцаж ирж зохион байгуулж явдаг аа гэсэн үг. Тэгэхээр энэ дээр яах вэ бид нар бас нэг санал нэмж оруулахын тулд гаалийн татвар дээр чөлөөлөөд өгчихвөл ядаж дотоодод үйлдвэрлэж байгаа түүхий эд дээр энэ асуудлуудыг бас удаа дараа ярилцсан, энэ дээр харин одоо ингээд хэлэлцүүлгийн шатанд энэ асуудлууд яригдаад шийдэгдээд явах байх аа гэж бодож байна.

Ер нь цаашид бас эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц, ялангуяа энэ томуу, томуу төст өвчний улирал эхэлсэнтэй холбоотой өргөн хэрэглээний жороор олгогддог эмийн сангуудаар жижиглэнгээр зарагддаг өндөр хомсдолууд бол үүсэж эхэлж байгаа. Дээрээс нь одоо энэ хил гаальтай холбоотой хэчнээн зохицуулалт хийж байгаа ч гэсэн тээврийн зардал өссөнтэй холбоотой, бас үнийн өсөлт нэмэгдэх ийм хандлага ажиглагдаж байгаа. Цаашид ч гэсэн одоо нөхцөл байдал үүнээс хүндрэх юм бол бас эмийн өсөлт нэмэгдэх ийм хандлага байна.

Дээрээс нь бас БНХАУ-ын ковидын нөхцөл байдал хүндэрч байгаа, бас хүндрэх юм бол энэ байдлаас өшөө хүндрэх юм бол, ялангуяа эмийн түүхий эд дээр нэлээн хомсдол үүснэ ээ гэсэн ийм эрсдэлүүд байна аа. Тэгэхээр бас эрхэм гишүүд та бүхэн бас энэ хуулийн төсөл дээр эм, эмнэлгийн хэрэгслийг ядаж гаалийн татвар

болон зарим түүхий эд дээр хөнгөлөлтийг үзүүлэх тал дээр хэлэлцэж шийдвэрлэж өгнө байх аа гэж бодож байна.

Ч.Хүрэлбаатар: Энхболд сайд аа. Энхболд сайд аа. Ер нь манай Засгийн газрын гишүүд нэг юм ойлгоорой. Та бүгд өргөн мэдүүлсэн юмаа л хамгаалж ярих үүрэгтэй. Тэгэхгүй болбол ингээд Их Хуралд өргөчхөөд, эсвэл Их Хурлын гишүүд нь шийднэ, эсвэл Их Хурал шийднэ. Ингэсэн, иймэрхүү маягаар бол юманд битгий хандаарай.

3 дугаар зүйлтэй асуулт дууссан.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Нэрсээ өгөөрэй. Сандаг-Очир гишүүн, Булгантуяа гишүүн, Пүрэвдорж гишүүн. Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Би энэ 4 дүгээр зүйл, 5 дугаар зүйл, 6, 7 гээд энд хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг ингээд хуульчлах юм уу? Монголбанк ийм арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Их Хурал ингэнэ, Засгийн газар ингэнэ гээд ингээд нэг бүрчлэн заагаад өгч байна. Хөдөө аж ахуй яам, Уул уурхайн яам. Та бүхэн яг Засгийн газар яг ирэх, ирээдүйд үүсэх нөхцөл байдлыг яг тэгвэл 100 хувь төсөөлж харж чадаж байгаа юм уу? Тэгсэн тохиолдолд хэрэгжүүлэх арга хэмжээгээ илүү сайн мэдэж байгаа гэж ойлгоно шүү дээ. Бид бүгд бол ирээдүйд эдийн засаг ямар болохыг хэн ч өнөөдөр маргаашийг тааж төсөөлөх аргагүй байна аа гээд байгаа шүү дээ. Тэгээд яг энэ хуульд зааснаас чинь авах авах арга хэмжээнүүд гээд заачихдаг өөр нөхцөл байдал үүсвэл яах вэ? Хуулийн заалтад ороогүй юм аа гээд тухайн үеийн нөхцөл байдлыг яах юм, хуульд өөрчлөлт оруулах юм уу, эсвэл одоо авч хэрэгжүүлэхгүй байх юм уу. Тийм учраас энэ яг нэг бүрчлэн ингээд заах, хэрэгжүүлэх арга хэмжээг хуульчилж өгөх нь хэр оновчтой юм бэ? Та бүхэн маань энэ талаар бас ярилцсан юм уу, үгүй юу? Надад бол ийм зохимжгүй л юм шиг байх юм. Энэ авах арга хэмжээгээ л 3 нэр төрлийнхөө бараан дээр ингэнэ гээд л. Тэгээд шаардлагатай арга хэмжээг нь тухайн одоо Засгийн газар өөрөө ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг тэгээд Засгийн газрын л эрх шүү дээ.

Ингээд хуульчлаад өгөх нь одоо энэ заалтуудаас өөр нөхцөл байдал үүсвэл яах вэ л гэж би асуух гээд байгаа юм. Тухайлбал өнөөдөр бид нар энэ хуулийг гаргах гээд л ингээд байж байх хооронд л одоо гурилтай холбоотой нөөцөө бүрдүүлнэ. Ингээд л ярьж байтал талхны үнэ чинь ингээд л 2 хоногийн дотор 200 төгрөгөөр өсчхөөд л байж байна шүү дээ. Энэ хуулийг гаргах гээд л байж байхад. Тэгээд цаашдаа хэдэн төгрөгөөр өсөхийг яаж ч мэдэхгүй байна. Энэ хууль хэзээ эцэслэн батлагдах вэ? Тэр хооронд юмны үнэ, гурил талхны чинь үнэ, махны чинь үнэ яаж өсөх вэ? Хүчит шонхор зах дээр чинь мах 16 мянга хүрчихлээ, энэ байдлуудаа та бүхэн юу гэж харж байгаа юм бэ гэдгийг бас ажлын хэсэг Сангийн сайдаас асууя.

Ч.Хүрэлбаатар: Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Тооцоололгүй яах вэ. Үйл ажиллагааг нь ингэж зааж өгөхгүй болбол хориглосон, хязгаарлагдчихсан тийм зүйлүүд их байгаад байгаа юм. Хориглоогүй, хязгаарлаагүй зүйлүүдийг бол Засгийн газар өөрийнхөө үйл ажиллагааныхаа хүрээнд авч хэрэгжүүлээд явна аа. Ер нь бидэнд маш хурдтай

ажиллах шаардлагатай байгаа. Таны саяын хэлдэг үнэн. Одоо бид нар энэ үнэ ханш бид нарыг ерөөсөө хүлээхгүй байгаа юм. Өдөр өдрөөр өөрчлөгдөж байна. Өдөр өдрөөр савлаж байна. Маргааш жишээ нь олон улсын зах дээр юу болохыг бид нар өнөөдөр хэлж мэдэхгүй. Тэнд нэг бөмбөг дэлбэрээд. Тэнд нэг хэлэлцээр хийгдэнгүүт л одоо үр дүнгээс нь шалтгаалж маш их савлаж байна. 2 сарын 24-өөс хойш үндсэндээ шатахууны үнэ гэхэд л 120-оос дээшээ 2 удаа гарлаа. 100 руу 2 ч удаа дөхөж ирлээ. Бүр 100-аас доошоо орсон. Өнөөдөр одоо бас ингээд 100-аас дээш гарчихсан ийм байдалтай 120 орчим дээш гарчихсан ингээд савлаж байна. Эдгээр бүх зүйлүүд бол манай дотоодод бол шууд нөлөөлж байгаа. Түрүүн Өнөрболор гишүүн хэлсэн манай бид ер нь худалдааны эдийн засагтай улс, ер нь 70 гаруй хувиа импортолж авч хэрэглэдэг. Одоо инфляцын ер яг үнэн. Тэр 51 тавиас дээш хувь нь бид, өөрөөр хэлбэл импортоор манай инфляцыг худалдаж аваад байна гэсэн үг бид инфляцаа.

Тийм учраас ингээд дотоодын үнэд ингээд хүчтэй нөлөөлж байгаа юм аа. Тэр дундаас яг энэ 3 дээрээ л арга хэмжээ авъя, гэхдээ яг ингэж хуульчилж, үйл ажиллагааг нь бүр нарийн зааж өгөхгүй болбол одоо энэ заалт болгон маань өөр хуулиар ингээд хязгаарлагдчихсан ийм зүйлүүд байгаа. Тухайлбал тэр Засгийн газрын үнэт цаас, баталгаа гэж байгаа юм. Төсвийн тогтвортой байдлын хуулиар төсвийн хуулиар Засгийн газрын үнэт цаас, Засгийн газрын баталгаа нь зөвхөн одоо тухайн жилийн улирлын шинж чанартай, одоо орлого тасалдвал төсвийн дутагдал одоо орвол үүнийг нөхөх зорилгоор тухайн жилдээ буцааж хаагдах ийм зорилгоор одоо зөвхөн гаргаж болдог. Тэгвэл энэ хуульд оруулж өгснөөрөө энэ 3 бүтээгдэхүүн дээр одоо шаардлагатай үед Засгийн газар шаардлагатай субъектэд нь үнэт цаас гаргая, баталгаа гаргая аа гэж байгаа юм. Тухайлбал шатахуун импортлогч нар банкнаас зээл авах хязгаарлалтдаа баригдаад бид шаардлагатай нөөцөө татаж чадахгүйд хүрвэл одоо давсан зээлийнх нь хэсэг дээр нь Засгийн газар яаралтай баталгаа гаргаж өгөөд тэр одоо эх үүсвэрийг нь гаргаад ингээд нөөцөө хангалттай хэмжээнд татъя аа гэсэн иймэрхүү зохицуулалтуудыг энэ хуулиар олгож байгаа юм аа.

Тэр деретив гэж байгаа юм. Төв банкны хувьд мөн л одоо шатахуун импортлогч нарт үндсэндээ зориулалт гаргана гэсэн үг. Төв банкаар бас ийм боломж нь маш хязгаарлагдмал байдаг. Бараг боломжгүй шахуу ийм байгаа юм. Импортлогч нарт одоо тогтвортойгоор шаардлагатай валютын эх үүсвэрийг нь ханшийн эрсдэлийг нь одоо бууруулж ингэж нийлүүлнэ гэж байгаа юм. Бас төв банканд бас ийм боломжийг энэ хуулиар олгосноор богино хугацааны энэ өндөр хэлбэлзэлтэй энэ санхүүгийн дарамтуудыг нь багасгана аа гэсэн үг. Гэх мэтчилэн энэ нөгөө Их Хурал, төв банк, одоо Монголбанк юу, Засгийн газар одоо өөрсдийн үйл ажиллагаандаа хязгаарлагдчихаад байдаг зүйлүүдийг нь тухайлан нарийвчилж оруулж байна аа гэж ойлгоорой. Баярлалаа.

Ч.Хүрэлбаатар: Булгантуяа гишүүн.

Х.Булгантуяа: Энэ авч хэрэгжүүлэх 10 арга хэмжээ гээд 4 дээр ерөөсөө энэ зүйлийг бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт хомстлоос сэргийлэх. Энэ арга хэмжээг аваад яг үнийн өсөлтөөс сэргийлэх яг ийм бид нарт тийм баталгаа байна уу? Нэгдүгээрт. Үнийн өсөлтөөс, одоо өнөөдөр ингээд л нэг түрүүн Сандаг-Очир гишүүн ч гэсэн хэлж байна. Өнөөдөр нэг үнэтэй, маргааш нэг үнэтэй, 7 хоногийн дараа ямар

үнэтэй байхыг нь бид нар мэдэхгүй байна аа. Тэгэхээр үүн дээр сөрөг нөлөө одоо энэ үнэ өсөхөөс бид нар үнийн өсөлт гэж томъёолох нь ч бараг зөв үү, буруу юу гэдэг л асуудал яг үнэнийг хэлэхэд үүсчхээд байх шиг байна. Бензин шатахууны үнийг ч гэсэндээ хэд болтол жилийн дотор энэ оны дуустал хэр ихээр өсөхийг нь бид нар магадгүй мэдэхгүй байх байх.

Сөрөг нөлөөллийг бууруулах гэдгийг бол ойлгож байна аа. Одоо үнийн өсөлттэй холбоотой сөрөг нөлөөллийг л арай багасгана аа гэж. Тэгээд тэгж уншигдаад байх юм. Та бүхэн маань үүнийг юу гэж харж байгаа юм бэ? Үнийн өсөлт

Дээрээс нь нэмээд хомсдолоос сэргийлэх гээд тэгэхээр яах вэ, би одоо нөөц бүрдүүлэлт дээр ерөнхийдөө бол ашиглах юм байна аа гэж ойлгож байгаа. Аль аль компаниудынх нь хувьд, үнийн өсөлтийг бид нар хэр болтол өсгөхгүй, одоо ингээд барьж чадна гэдэг та бүхэн энэ хуулийн дагуу тийм баталгаа зохицуулалт юу байна аа.

Ч.Хүрэлбаатар: Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Эхлээд тэр нэр дээр ярьж байна. Үнийн өсөлт гэх нь одоо зөв байх аа. Одоо бид өөрөөр яаж орчуулж тавих вэ? Үнийн өсөлтийг хэнд ч ойлгомжтой болов уу гэж ингэж бодож байна. Үнийг тогтвортой байлгах ийм л зорилготой хууль учраас ер нь л энэ 3 гол бүтээгдэхүүн дээрээ болбол одоо байгаа, одоо тогтчихоод байгаа энэ үнэ ханш дээр нь болбол энэ жилийн хугацаанд ямар ч байсан энэ хуулийг одоо үйлчлэх хугацаанд маш сайн үр дүн гарах ийм хууль болно оо гэж ингэж харж байгаа юм. Одоо энэ хуулиараа ч Засгийн газар одоо үүргээ авна, Их Хурал ч гэсэн Засгийн газартаа итгэж ийм том боломж өгч байгаа учраас бид хичээж ажиллана аа. Маш сайн тооцоолж одоо нэг ч гэсэн юм орхичихолгүй шиг л одоо хуулиа хичээж оруулж ирж байгаа. Тэгэхээр валют одоо тухайлбал энэ хууль хэрэгжмэгц, хэрэгжсэнээр өнөөдөр байгаа бензин клонкууд дээрх шатахууны үнэ ханшийг одоо байгаа хэмжээнд нь, ер нь бараг нэг хэсэгтээ дотооддоо нийлүүлэлт дээрээ тогтвортой байлгачих болов уу гэж ингэж харж байгаа.

Мах дээр ч гэсэн дээ, мах дээр бол бид нөөцийн махан дээр гол менежментээ хийнэ, нөөцийн мах дээр гол менежментээ хийнэ. Нийт хүн амын маань тал нь одоо Улаанбаатар хотод байж байна. Тэгэхээр Улаанбаатар хотод нөөцийн махаар нь хангалттай нийлүүлнэ. Үүгээр дамжуулж одоо махны зах зээл дээр интервенц хийж үнэ ханшийг тогтвортой байлгах тал дээр үр дүнтэй ажиллана аа гэж ингэж харж байгаа юм.

Гурилаар дамжаад бүх бүхий л гурилан бүтээгдэхүүний түрүүн Сандаг-Очир гишүүний хэлсэн талх гэлээ, гол түүхий эд гурил. Тийм учраас энэ гурил дээр одоо жишээ нь өмнөх жилүүдийн хураагаад авчихсан буудай нөөц нэлээн байна. Үүнийгээ гурилын үйлдвэрүүддээ өгч чадахгүй, гурилын үйлдвэрүүд нь авах боломжгүй ийм тулчихсан гацаатай байна. Тариаланчид ийм учраас одоо энэ жилийнхээ тариалалтыг хийх эх үүсвэр дутмаг байна гээд иймэрхүү түгжээ, иймэрхүү гацаануудыг арилгаснаар энэ зах зээлийн эргэлтэд орж үнэ нь тогтвортой байх, мөн хойтонгийн ийм нөөцийн дутагдалд орохоос одооноос сэргийлж, зах зээлээ тогтвортой байлгах ийм арга хэмжээнүүдийг энэ хуулиар бид давна аа. Ийм зорилт

тавьж ажиллана аа. Ер нь бол хууль нь батлагдаад ажиллаад эхэлмэгц үр дүн гарна аа гэж зорьж байгаа юм.

Ч.Хүрэлбаатар: Пүрэвдорж гишүүн асуулт асууя.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр Жавхлан сайд одоо манай намын нэг нөхөртэй холбоотой энэ төмөр замын асуудал ярьж байх шиг байна. Тэгэхээр би энэ дээр тодорхой зүйлийг хэлье. Манай Монгол Улс бол хойд Орос улстайгаа тарифын асуудалтай, урд хөрштэйгөө бол царигийн асуудалтай байдаг юм. Тэгэхдээ тарифын асуудал гэдэг юу вэ гэх дээр 2, 3 жилийн өмнө Оросын холбооны улстай транзит тээвэр дээр тарифын хямдрал үзүүлэхээр ингэж тохирсон. Энэ одоо гэрээ бол Монгол Улсад ашиггүй гэж би үзэж байгаа. Өөрөөр хэлбэл Монгол Улсын нутаг дэвсгэрээр би ойролцоогоор нэг 20 сая орчим тонн ачаа явдаг гэж ойлгож байгаа. Гэтэл энэ Монголоос гардаг бүтээгдэхүүн дөнгөж гучхан мянган тонн байна. Манай Монгол Улсад 600 дахин ашиггүй ийм зүйл байхгүй юу даа. Тэгээд энэ хямд тарифт энэ хэлэлцээрийг хийхдээ ямар зорилго тавьсан бэ гэхээр Владивостокоор нүүрсээ гаргана гэдэг ийм зорилтын хүрээнд энэ одоо хямд тарифын хэлэлцээрийг хийсэн. Харамсалтай нь тийшээ 1 килограмм ч одоо нүүрс гараагүй байж байна. Тэгэхээр энэ бол Монгол Улсад ашиггүй хэлэлцээр юм аа.

Тийм учраас энэ хэлэлцээр ямар хорлонтой зүйлийг бий болгоод байна вэ гэхээр транзит тээвэр одоо жишээ нь Замын-Үүд-Эрээний боомтоор өдөртөө 14 состав вагоныг гаргадаг, түүний найм нь транзит тээвэр болчихоод байгаа байхгүй юу. Зургаа нь зургаагийнх нь дөрөв нь уул уурхайн бүтээгдэхүүний Монголын уул уурхайн бүтээгдэхүүнийх, тэгээд 2 нь болохоор бусад бараа бүтээгдэхүүн байж байгаа юм. Тэгэхээр энэ транзит тээвэр хямд болох дээр тэнд одоо Монголын гаргах ёстой уул уурхайн бүтээгдэхүүн тэр транзит тээврээс заставаар нь гарахгүй. Ингээд одоо бид нар валютын орлого олж чадахгүй ийм нөхцөл байдалд ороод байгаа. Тийм учраас энэ дээр энэ хэлэлцээр дээр бас эргэж хараад тэр одоо 8 байлаа гэхэд ядаж одоо нэгэнт л 2 хөрштэйгөө хэлдэг учраас түүнийг 6 болгодог ч юм уу. Ийм байдлаар бид нар тэр транзит тээврийг нь багасгаад уул уурхайн бүтээгдэхүүнээ экспортлох юм болбол илүү үр дүнд хүрнэ гэж үзэж байгаа.

2 дахь асуудал нь царигийн асуудал байгаа. Төмөр замаас баримтлах бодлого баримт бичгийн хүрээнд бол 1520 царигтай байх ёстой. Одоо хөндөлдсөн юм уу огтлолдсон тохиолдолд. Бүтээгдэхүүн нь экспортод гарч байгаа уурхайгаас хил рүү тавьж байгаа тэр царигийн асуудлыг бол Засгийн газар Улсын Их Хуралд оруулж танилцуулснаар шийднэ гэж байгаа юм. Тэгээд үүний дагуу 20141 онд Таван толгойгоос Гашуун сухайт хүртэл төмөр замыг нарийн төмөр зам царигаар тавихаар одоо шийдвэрлээд байсан. Түүнийг нь 2020 онд Үндсэн хуулийн цэцээр хүчингүй болгосон. Тэгэхээр одоо өнөөдөр ямар зүйл үлдсэн бэ гэхээр Их Хурал руу та бүхэн яаралтай энэ царигийн асуудлыг оруулж ирээд одоо өөрөөр хэлбэл тэр хүртэл өргөн төмөр замаар тавьчихсан байж, тэгэхээр наад талдаа буулгах терминалыг нь байгуулаад цаашаа одоо тэр нөгөө нэмүү өртгөө энэ Монголдоо авч үлдээд цаашаа нарийн төмөр замаараа нэг 10 километр ч юм уу, 5 километр гаргаад ингээд экспортоор шууд явуулах ийм боломж нь байж байгаа. Тэгэхээр Засгийн газар энэ хүрээнд энэ царигтай холбоотой асуудлаар хуулийн төслөө оруулж ирэх үү. Монгол Ардын нам бүлэг энэ дээр ямар бодолтой байгаа юм бэ гэдгийг асууя.

Ч.Хүрэлбаатар: Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Эхнийх нь бараг санал хэлчих шиг боллоо. Ер нь санал нийлж байна эхний асуудал дээр нь. Гэхдээ Пүрэвдорж гишүүн ээ, тэр урагшаагаа 14 состав гарч байгаа асуудал дээр бол ийм шүү. Энэ яг олон улсын төмөр замын энэ конвенцоороо бол манайд олгогдож байгаа, олгож байгаа ч юу байх вэ одоо манай байгаа төмөр замын суурь дэд бүтцийн хүчин чадал нь ерөөсөө энэ. Цаашаагаа бид нар үүнийг нэмэх нь бол чухал байхгүй юу. Улаанбаатар төмөр зам хувь нийлүүлсэн нийгэмлэгийн хувьд бид нар 50, 50 хувь байдаг, одоо түүн дээр маргах юм байхгүй, 50, 50 хувиараа л одоо энэ транзит хийхээс өөр арга байхгүй, гол нь тэр 14-өө л нэмэх хэрэгтэй байгаа юм. Тэгэхийн тулд манай энэ нэг урсгалтай энэ одоо хойд хилээс урд хил хүртэлх Улаанбаатар төмөр замын энэ суурь дэд бүтцийнхээ хүчин чадлыг нэмүүлэх хэрэгтэй. Оруулгуудыг хийх хэрэгтэй, өртөөнүүдийг нэмэх хэрэгтэй, зөрлөгүүдийг нэмэх хэрэгтэй. Мөн Эрээнээс цаашаа Жиньин хүртэлх тэр чинь бас нэг урсгалтай, бас нэг урсгалтай. Тэгэхээр тэр хооронд харин сайн мэдээ хэлье. Саяхан Хэрлэн дарга урагшаагаа, урд нөхдүүдтэй хэлэлцээр хийгээд манайх дотооддоо зөрлөгүүдээ нэмье, оруулгуудаа нэмье. Хятадын тал мөн Эрээнээс Жиньин хүртэлх тэр хэсэг дээр би тоог нь санахгүй байна, хэд билээ. Зөрлөгүүдийг нэлээн нэмэхээр болсон байгаа юм. Тэгэхээр энэ 14 состав 20 хүртэл нэмэгдэх ийм одоо боломжтой болж ирж байгаа юм. Үүнийг ойрын хугацаанд яаралтай хийх шаардлагатай болж ирж байна. Тэгэх юм бол манай экспортын хэмжээ нэмэгдэнэ. Мөн Ханги дээр ингээд төмөр зам нэмэгдэж байна.

Тийм учраас Эрээний Замын-Үүдийн ачаалал нэлээн багасна, тийшээгээ шилжинэ. Гашуун сухайтыг мөн яаралтайгаар урагшаагаа шууд нэвт гаргадаг энэ юмнуудаа яаралтай хийх хэрэгтэй байгаа. Тэгэх юм болбол одоо ганц Замын-Үүд биш ингээд Бичигтийн боомт байна. Мөн Шивээхүрэнгийн боомтууд байна. Эд нар орох юм болбол ингээд 4-5 боомтоор зэрэг төмөр замаар ачаа тээврийн эргэлт нэмэгдэх юм болбол манай экспортууд хэд дахин нэмэгдэх ийм боломжтой байгаа юм.

Тэр царигийн асуудал бол шийдчихсэн шүү дээ. Пүрэвдорж гишүүн ээ, одоо дахиж Их Хурлаар оруулж шийдээд байх асуудал ерөөсөө байхгүй. Харин гацчихаад байсан хилийн боомтууд дээрх солбицлын цэгүүдээ харин сая бид эцэслэн тохирчихлоо, одоо саад байхгүй. Одоо дандаа бүтээн байгуулалтууд ТЭЗҮ, энэ асуудлууд л яригдана. Бид дотооддоо бол үндэсний төмөр замын бүх суурь дэд бүтцүүд болбол өргөн царигаараа явна. Хил дээр харин цаанаас нь арай орж ирэх манайх өргөн орох, цаашаагаа орох, мөн тэр хил дээр байгуулагдах ачиж буулгах, шилжүүлэн ачих тэр терминалууд наана хийх үү, цаана хийгдэх үү гэдэг бол маш тодорхой олон улсынхаа конвенцоороо явчихна. Манайх экспорт хийж байгаа бол тэр терминал хилийн цаана, цаанаас наашаа экспорт хийж байгаа бол хилийн наана хийгдэнэ гээд ерөөсөө олон улсын дүрэмтэй, үүгээрээ ингээд л явчихна.

Ч.Хүрэлбаатар: Пүрэвдорж гишүүн тодруулъя.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр би бол зүгээр яах вэ дээ. Энэ үнэ тогтворжуулж байгаа энэ хөтөлбөрийн чинь хүрээнд хамгийн гол нь бараа бүтээгдэхүүний үнээ тодорхой хэмжээгээр Монголын бүх хүнд хямд хүргэх зорилтыг агуулж байгаа. Тийм учраас дэмжээд байгаа юм. Харин энэ хүрээндээ бид бүхэн орлого талдаа илүү сайн ажиллах ёстой шүү л гэж би сануулж хэлээд байгаа юм. Орлого талдаа сайн

ажиллуулахын тулд төмөр замын энэ ерөөсөө энэ ложистикийн хямрал бол хамгийн том хямрал байгаа, тэнд одоо төмөр замын хямрал чинь түүний чинь хамгийн өндөр хувьтай байгаад байгаа юм шүү. Тэр нөгөө нэг ачаа авто тээврийн тээвэр хийх нь бол одоо төмөр замтай бол тэр ямар ч ач холбогдолгүй болно. Тийм учраас төмөр замын асуудлаа маш хурдан шийдэх ийм асуудлыг л хийж байж бид нар энэ орлого талдаа илүү сайн ажиллаж байж л бид нар энэ хямралыг давна уу гэхээс биш одоо ингээд жил болгон ингээд тогтворжуулах хөтөлбөр хийгээд ингээд явах юм болбол бид нарын амьдрал огт сайжрахгүй ээ гэдгийг хэлье.

Ч.Хүрэлбаатар: Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Өнөрболор гишүүнээр тасалъя. Тэмүүлэн гишүүн асууя. Пүрэвдорж гишүүнийг нэмчхээрэй.

Г.Тэмүүлэн: Би энэ 5.1.6 дахь заалттай холбогдуулаад тодруулах гэсэн юм Монголбанкнаас. Тэгэхээр энэ дээр бол яах вэ Лондонгийн металлын биржийн үнэ дээр 5 хувийн нэмэгдэлтэйгээр гадаад дотоодын зах зээлээс алт худалдан авч, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх ээ гэдэг энэ заалт болбол орж ирсэн байгаа. Тэгэхээр яах вэ би зүгээр ямар нэг байдлаар одоо Монголбанк энэ гадагшаа гараад байгаа алтыг зогсоож бас Монголбанк алтныхаа нөөцийг нэмэгдүүлэх гэсэн санаа болбол бас үүгээр энэ үндсэн дээр энэ заалтыг орууллаа гэж бол бас ойлгоод байгаа. Гэхдээ би зүгээр үүнтэй холбогдуулаад нэг асуухад 2010-14 он хүртэл болбол алтны олборлолтын хэмжээ нь бол буурч байсан.

Бид нар алт-1, алт-2 гэдэг хөтөлбөрийг хэрэгжүүлсний үндсэн дээр одоо болбол тухайн үед магадгүй 2010 онд одоо нэг 2 тонныг л Монголбанканд тушаадаг байсан бол одоо бол доод тал нь ерөөсөө 20 тонноос буухаа больчихсон. Энэ оны хувьд бол өшөө бүр өмнөх оноосоо 10-20 хувийн өсөлттэй байгаа. Энэ оны 1 сард би зүгээр цахим дээрээс харсан мэдээллээр ингээд аваад үзэхэд 1,6 тонн алтыг 1 сард худалдан авсан буюу энэ маань одоо нэг 20 орчим хувиар илүү өмнөх оныхтой харьцуулахад илүү байна аа гэсэн тооцоо гарч байна гэж хараад байсан юм.

Тэгэхээр ерөөсөө энэ заалтын маань шаардлага ер нь байгаа юм уу? Эсвэл хулгайгаар хилээр гадагшаа тэгж их алт өшөө бас ингээд бид нарын энэ алт-1, 2 хөтөлбөрийг хэрэгжүүлснээс хойш Монголбанканд тушаахгүй тийм их олон тонны хэмжээний алт байгаа юм уу. Энэ дээр та хэд манай бас одоо магадгүй тагнуултай хамтраач гэдэг юм уу, тодорхой тооцоо судалгаа хийсэн зүйл байгаа юм болов уу? Жилийн жилд л ерөөсөө байнгын өсөлттэй Монголбанканд би тушааж байгаа алтны хэмжээ болбол нэмэгдээд байна аа л гэж бас ойлгодог. Нэгд.

Хоёрт, алт өөрөө бол яах вэ хатуу валют. Тэгэхээр нэг талдаа бас зарим судлаач нарын ч яриад байгаагаар ер нь зүгээр энэ долларыг бол алт олборлож болно оо гэсэн нэг санааг бас дэвшүүлээд байгаа юм. Доллар дээр үүсээд байгаа одоо долларын ханшийн өсөлт гэдэг юм уу, валютын ханшийн өсөлтийг энэ дээр бөөгнөрөөд байгаа эрэлтийг алт руу шилжүүлбэл магадгүй өнөөдрийн энэ ханшийн өсөлт болбол намжина аа гэсэн нэг тийм асуудал яриад байгаа юм. Тэгэхээр энэ бас байж болдог юм уу? Ер нь зүгээр бусад өөр улс орнуудад ч гэсэн бас нэг ийм жишгүүд болбол байдаг. Тодорхой Монголбанкнаас тодорхой төв банкнаас нь үүнийг тодорхой зөвшөөрөл болгоод шийдээд явдаг. Магадгүй манай урд хөршид ч гэсэн иргэд нь өөрсдөө чөлөөтэй бас алт худалдаж аваад эргээд магадгүй тэр валютын ханшийг

бууруулах ч гэдэг юм уу ийм зохицуулалтуудыг хийдэг гэсэн маневар яриад байгаа, би бол нарийн ширийнийг нь сайн мэдэхгүй байгаад байгаа юм. Энэ дээр бас нэг тодорхой нэг хариулт өгөөч гэсэн санаа хэлэх гээд байгаа юм.

Ч.Хүрэлбаатар: Лхагвасүрэн Ерөнхийлөгч хариулъя, ажлын хэсгийн 3 дугаар микрофон.

Б.Лхагвасүрэн: Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя. Ер нь бол энэ 22 онд бол одоо Монголбанк нэг 24 орчим тонн алт авчих болов уу гэж л одоо бид төсөөллөө хийгээд явж байгаа. Өнгөрсөн онд бол 20 тонн алт авсан. Яах вэ энэ 5 хувийн нэмэгдлийг өгснөөрөө ямар ч байсан одоо хууль бусаар Монгол Улсаас авч гарах алт эс үгүй бол хууль бусаар ингээд дотооддоо бас нэг барьцаа болгоод зээлийн барьцаанд тавиад байдаг, хоорондоо өгч явалцаад байдаг энэ алтны арилжаа багасах болов уу гэдэг хувилбараар л үүнийг оруулсан байгаа юм. Тэгэхээр ерөнхийдөө бол Монголбанк бол алтыг төгрөгөөр худалдаж авдаг, ингээд алт маань өөрөө манай Монгол Улсын валютын нөөц болоод явчихдаг учраас эргээд ингээд нөөцдөө бол маш их тийм дэмжлэг болоод явдаг. Жилдээ бол 20 тонн алт бол ерөнхийдөө 1 тэрбум орчим долларын л үнэлгээ болж байгаа. Тэгэхээр бол нэг тэрбум орчим долларыг л найдвартай тогтвортой байлгах л нөөц дээрээ байрлах ийм боломжийг бүрдүүлдэг юм.

Таны дараачийн асуулт төгрөгөөс, төгрөгийн өгөөжөөсөө арай өөр тийшээ ингээд зугтах гээд валют руу ч юм уу, өөр юм руу орох гэж байгаа улсуудад бол мэдээж олон улсад бол ийм хадгалахаар ийм бас стандартын бараа шиг зардаг бол алт байдаг. Монголбанкны хувьд ч гэсэн бас өөрийнхөө гадна цэвэршүүлсэн Монголынхоо алтыг 100 граммаар нэг унц буюу 33, 32 граммаар ингээд бас савлаад одоо барааны тэмдэгт бүх юмыг нь тавиад ингээд бас Монголбанкнаасаа зардаг. Тэгэхээр бол ийм юм бол бас зүйл байгаа. Тэгэхээр иргэд бол Монголбанкны манай нөөцийн удирдлагын тэнд байгаа тэр 100 граммаар сав баглааг нь хийчихсэн тэр алтыг өнөөдрийнх нь дэлхийн зах зээлийн үнийн ханшаар худалдаж авч болно.

Ч.Хүрэлбаатар: Тэмүүлэн гишүүн тодруулъя.

Г.Тэмүүлэн: Тэгэхээр нөгөө эхний асуултад би тодруулаад байгаа зүйл маань л бид нар яах вэ, алт-1, 2 гэдэг хөтөлбөрийг ингээд 2014 оноос хойш хэрэгжүүлээд явсан. Алт-2 хэрэгжээд гэдэг юм уу, өнгөрсөн онд Алт-2 үндэсний хөтөлбөрийг эрчимжүүлэх зорилгоор одоо олгож байгаа хөнгөлөлттэй санхүүжилтийн хүрээнд бол нийтдээ 2021 онд нэг 17 аж ахуйн нэгжид 333 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон гэж байгаа юм. 333 тэрбум төгрөгийн. Тэгэхээр нэг талдаа одоо дахиад 5 хувиар нэмэгдүүлнэ ээ гэдэг энэ асуудлыг тавьж байгаа болбол бид бүхний энэ Алт-2 хөтөлбөрийн хүрээнд олгож байгаа энэ санхүүжилт маань бас яг хангалттай бүрэн дүүрэн байгаа онохгүй байна гэсэн үг. Түүнээс гадуур дахиад магадгүй 10, 15 хувийн ч гэдэг юм уу тийм нөөц орон зай үүсээд байна гэсэн үг үү. Би бол бараг л бичил байна уу, бүх л алт олборлогч нар бол бүгдээрээ л Монголбанканд тушаадаг болчихсон гэж ойлгоод байгаа юм. Гэтэл тэнд дахиад нөөц орон зай байгаа юм уу? Уг нь бол энэ хөтөлбөр маань амжилттай хэрэгжээд санхүүжилт, зээл нь одоо ингээд л байгаа оноод яваад байна гэж уг нь хараад байгаа юм.

3. **Ч.Хүрэлбаатар:** Хариулъя, Монголбанкны Ерөнхийлөгч Лхагвасүрэн микрофон

Б.Лхагвасүрэн: Тэмүүлэн гишүүний асуултад тодруулъя. Тэгээд ерөнхийдөө яг одоо 17 аж ахуйн нэгж 333 тэрбум төгрөг гэдэг бол нийт яг бүх алт олборлодог аж ахуйн нэгжүүд биш л дээ. Энэ яг банкны шалгуур үзүүлэлтэд тэнцээд банкаар дамжаад энэ зээлийг авах ийм шалгуурыг хангасан аж ахуйн нэгжүүд, шалгуур хангаагүй аж ахуйн нэгжүүд бас олон байдаг. Тэр утгаараа бол яг бүгдийг нь хамарч чадаагүй учраас хамрагдаагүй хүмүүс нь ч гэсэн төв банкн дээр алтаа бол авчрах л ёстой, хуультай, Монголоос олборлосон алтаа бүгдийг нь. Тэгээд дээр нь бас олон улсын мэдээллүүд явж байгаа. Жишээлбэл, БНХАУ-ын одоо нэг хотод гэртээ алт нуучихсан иргэний гэрээс нэлээн том хэмжээний 10 гаруй тонн ийм алт гараад, тэгээд энэ тодорхой хэсэг нь бол Монголоос авсан алт аа гээд ингээд ийм бүр олон улсын баталгаатай мэдээллээр ингээд явж байсан учраас Монгол Улс бол бас ингээд нууцаар хууль бусаар алдсан гарч байгаа процесс бол бас тодорхой хэмжээнд ... /минут дуусав/

Ч.Хүрэлбаатар: Тэмүүлэн гишүүн тодруулъя аа. Ер нь Тэмүүлэн гишүүн бол хэд ч тодруулж болно шүү дээ. Тодруул, тодруул.

Г.Тэмүүлэн: Тэгвэл саяын энэ Лондонгийн металын биржийн үнэ дээр 5 хувийн нэмэгдэлтэйгээр худалдан авна аа гэж байгаа энэ нөөц нэмэгдүүлэх механизм маань саяын та бүхний Монголбанкнаас тавьж байгаа шалгуураас гадуур байгаа аж ахуй нэгжүүдэд олгох түүнийг гадуур байгаа тэр алтыг болбол татаж авах, цуглуулах л зохицуулалт юм байна шүү дээ гэж ойлгох уу? Зөв үү тийм ээ.

Ч.Хүрэлбаатар: Хэн хариулах вэ. Лхагвасүрэн, Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Тэмүүлэн гишүүн маань сайн ойлгож байгаа байх аа. Ер нь Монгол Улсын хувьд бид валютынхаа нөөцийг бүрдүүлэх ерөөсөө бидэнд гуравхан эх үүсвэр л байдаг. Экспорт хийх, гадаадын зээл тусламж, алт. Бид нар нөгөө газрынхаа хэвлийд валютыг нь нөөцтэй улс байхгүй юу. Тэгэхээр энэ богино хугацаанд бид нар валютынхаа нөөцийн одоо ийм шоктой үед нэмэх гуравхан эх үүсвэрүүдээрээ л одоо ажиллахаас өөр зам байхгүй. Алтан дээр бол одоо ингээд алтны захын либералчлах алтны үйлдвэрлэлийг дэмжих гээд дунд хугацааны хөтөлбөрүүд явж байгаа зээл энэ тэр гээд. Тэр чинь болбол ингээд нэг жил, хоёр жилийн ингээд үр дүн гаргах богино хугацаанд бидэнд үр дүнгээ өгөх юм бол биш. Тэгээд богино хугацаанд үр дүнгээ өгөх юм нь олборлочихсон, төв банк нь орж ирж тушаагдахгүй байгаад байгаа алтуудыг татвараас ийм татварын дарамтаас болоод, эсвэл одоо энэ АМНАТ-ын юунаас болоод төлбөрөөс болоод тэгээд ингээд гадуур байгаад байгаа алтнууд бас, бид нар яг тоо ... /минут дуусав/

Ч.Хүрэлбаатар: Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: 2 асуулт байгаад байгаа юм. Нэг нь энэ арилжааны банкнуудын зээлийн хүүг бууруулах талаар Монголбанк ер нь ямар бодлогын чиглэл барьж ажиллаад байгаа юм бэ? Бид гайгүй явуулъя гээд л зүтгэснээ сүүлдээ төр хүүгийн тодорхой хэсгийг даадаг болчinguут сонирхолгүй болгочхож байгаа юм л даа, ер нь

бол яг нарийндаа. Тэгээд энэ тал дээр ямар юм бодож байгаа юм гэдэг нэг ийм асуудал.

Хоёрдугаарт, сая яг энэ асуудал дээр их сонин юм байгаад байгаа юм. Гадаад зах зээл дээр байж байгаа алтны үнээс өндөр үнээр гаднаас алт оруулж ирэхээр зэрэг жоол бэлэн цаасан валютаа л гадагш нь гаргана биз дээ. Гадаад зах зээлээс бидэнд Монгол мөнгөөр алт зардаг юу гэж байхгүй шүү дээ. Энэ чинь гадаад зах зээлээс алт ав гээд байгаа шүү дээ. Тэгэхээр би үүнийг чинь гайхах гайхаад байгаа байхгүй юу. Өндөр үнэтэй алт гаднаас оруулж ирж энд цусаа хийж доллароо гадагш нь хүргэх гээд байгаа энэ чинь ямар учиртай юм.

Хоёр дахь нь биржийн үнээс заавал 5 хувиар илүү ав гэдэг ийм заалт болчихоод байгаа байхгүй юу. Ядаж тэр Лондонгийн биржийн үнээр буюу бүр аргаа ядахад 5 хүртэл хувиар илүү авч болох юм гэж хэлэхгүй бол тэр биржийн үнээс 5 хувиар илүү ав аа гээд заачхаар зэрэг ямар ч тохиолдолд яг шууд 5 хувиар авна. Ийм заалт байж болох юм уу нөхдүүдээ, энэ чинь.

Ч.Хүрэлбаатар: Эхнийхийг Жавхлан сайд, дараагийнх нь Лхагваа Ерөнхийлөгч хариулъя. Жавхлан сайд.

Б.Жавхлан: 5 хувь нь бол ийм учиртай шүү, Батжаргал гишүүн ээ. Одоо АМНАТ 5 хувь, 5 байгаа юм. Лондонгийн одоо бид манай гол түүхий эдүүдээс ерөөсөө хамгийн либерал зах зээл нь манай алтны зам байгаа юм. Бид чинь нүүрсээ ингээд л өчнөөн тээвэр хийгээд л, бүр гаргаж чадахгүй. Нөгөө л нэг том биржүүдийн ханшаар чинь алинаар нь ч сааж чаддаггүй байхгүй юу, алийг нь ч тэр. Ганцхан бид алтаа шууд төв банкандаа Лондонгийн биржийн ханшаар өгдөг ганц бүтээгдэхүүн. Тэгээд энэ дээр одоо төв банканд дээр орж ирэхгүй гадуур нэлээн алт байна гэж бид нар хараад байгаа юм. Ер нь ч байгаа. Хэмжээг нь хэлж мэдэхгүй байгаа. Үнэхээр тоолж хэлж мэдэхгүй байгаад байгаа юм. Ашигт малтмалын хэрэг эрхлэх газар байдаг уурхайн тайлантай нь харьцуулаад үзэхээр нэлээн зөрүү гараад байдаг юм. Нэлээн зөрүү гараад байгаа юм.

Тэгэхээр гадуур байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр түүнийг авчрахын тулд зүгээр энэ одоо хуулийн хугацаанд шүү дээ. Энэ жилийн хугацаанд тушаах алтууд дээр ингээд премиум төлж байгаа юм. Яаралтай тэр далд байгаа алтнуудаа авчраад тушаа. Тэгээд рояалтиг чинь үндсэндээ нойллож байна гэсэн үг байхгүй юу. Бид нар рояалтынхаа хуулийг тэгж өөрчлөхгүйгээр энэ талд нь премиум өгчихөөр эффект нь байхгүй болж байна л гэсэн үг. Нөгөө татварынхаа хуулиар хэдүүлээ оролдоод яах юм. Тэр нь түүндээ байж байг.

Ингээд тэр татварын дарамтад нь үндсэндээ өршөөл үзүүлж байна гэсэн үг байхгүй юу. Ингээд нэг тушаагаадахаач ээ. Өөрөөр хэлбэл Монголын хөрснөөс гарсан 1 грамм алт болгон одоо эх оронч байх хэрэгтэй. Эндээ авчраад тушаагаадах, түүний төлөө үүнийг өгч байгаа л ийм ийм зүйл юм байгаа юм. Энэ урт хугацаанд болбол тийм сайн зүйл бол биш. Энэ жилдээ бид бол богино хугацаанд, одоо гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх л ийм л одоо бас л аргаа барсан л арга хэмжээ. Гэхдээ шаардлагатай зүйл гэж ингэж харж байгаа.

Ч.Хүрэлбаатар: Лхагва Ерөнхийлөгч нэмж хариулъя.

Б.Лхагвасүрэн: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Улсын Их Хурлаас 2020 оны 10 сард зээлийн хүү бууруулах стратегийг батлаад түүний дагуу бол нэлээн ажил хийгдээд явж ирсэн. Ялангуяа 21 онд зээлийн хүү бол нэлээн идэвхтэй буурч байсан. 13,4 хувь, одоо ер нь нэг сарын өмнө бол яг л ийм хэмжээнд очиж буурсан. Тэгээд одоо энэ нөхцөл байдал энэ олон улсын хурцадмал байдалтай холбоотойгоор эргээд одоо Монголбанк дээр ханштай валютын нөөцтэй холбоотой дарамт гарч байгаа учраас эргээд бид нар бол төгрөгийн өгөөжийг нэмэгдүүлэх зайлшгүй бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байгаа. Тэгээд бодлогын хүү 9 болж өөрчлөлт нэмэгдсэн 6,5-9 гээд, 2,5 нэгж хувиар нэмэгдсэн байгаа. Үүнтэй холбогдуулаад одоо зээлийн хүү буцаад өсөөд эхэлсэн байгаа юм. Ерөнхийдөө бол сүүлийн авч байгаа мэдээллээр бол зээлийн дундаж хүү бол 2 нэгж хувиар нэмэгдсэн гэсэн ийм статистик байгаа.

Бид нар гадаад зах зээлээс алтыг бол авдаггүй, гадаад зах зээлээс авна гэхлээр доллароор авна гэсэн үг. Монголдоо авдаг нь бол угаасаа Монголбанк өглөөний одоо Лондонгийн металлын биржийн үнийг аваад тэгээд тэр металлынхаа биржийн үнийг төгрөг рүү шилжүүлээд ингээд үнэ тогтоодог. Тэгэхээр бидний өнөөдөр Монголдоо авч байгаа алтыг төгрөгөөр худалдаж авдаг, валютаар авдаггүй ... /минут дуусав/

Ч.Хүрэлбаатар: Жавхлан сайд.

Б.Жавхлан: Хятадууд энэ алтан дээрээ маш либерал, манайтай яг ижил, одоо энэ гаргах гэж байгаатай ижилхэн тийм премиум төлж авдаг, Лондонгийн хагшнаас өндөр авдаг Хятадууд. Тийм учраас манайхаас алт гараад байдаг байхгүй юу далдуур. Манай авч байгаа төв банканд өгч байгаа ханшнаас өндөр яваад байдаг учраас аваад байдаг. Нэг тийм юм байгаа. Манай одоо нэмж байгаа чинь одоо тэд нартай өрсөлдөхүйц нь энэ дээ ийм татах хүч бий болгох гэж байна шүү дээ. Тэгэхээр зөвхөн одоо дотоодоос биш хэрвээ гаднаас манайхаас Хятад руу зөөгөөд байдаг шиг манайх руу одоо алтан өөд авчирвал бид нар авна шүү л гэсэн санаа.

Ч.Хүрэлбаатар: Үгүй ээ үгүй, энэ дээр би хар аа, Батжаргал гишүүний Пүрэвдорж оо, өнөөдөржингөө ярилаа шүү дээ, өөрөө. Батжаргал гишүүн маш логиктой юм асуугаад байна шүү дээ. 5 хувийн премиумтай өндөр үнээр алтаа зарчхаад, мэдээж Лхагваа Ерөнхийлөгч сая төгрөгөөр худалдаж одоо худалдаж авна аа гэж байна. Авангуутаа, түүнийгээ буцаагаад доллар болгочхоод байвал дахиад тэр 5 хувийн илүүдэл чинь яваад байна шүү дээ. Тэгэхээр эргээд гараад байж магадгүй гэсэн агуулгаар нь яриад байгаа юм. Тэгэхээр адилхан юм биш үү. Харин ч илүү алдах тийм магадлалтай юм биш үү гээд.

Хятадын хувьд бол алт гаргахыг бүр хуулиараа хориглочихсон байхгүй юу. Манайх бол тэр нь бол одоо зүгээр байж байж болно гэсэн үг. Тэгэхээр яг энэ дээр үүнийг хаасан ямар заалт байгаа юм бэ л гэсэн үг. Үгүй ээ, үгүй. Оруулж ирээд доллароо буцаагаад аваад гарвал яах юм. Одоо жишээлбэл би орж ирээд алтаа зараад гаднаас алт оруулж ирээд зараад төгрөгөөр авчихлаа шүү дээ. Төгрөгөө л шууд газар дээрээ доллар болгоод, үгүй ээ өнөөдөр биш л дээ ер нь, тийм байдалтай байх юм биш үү гэж байгаа юм.

Үгүй, үгүй, гадаад зах зээл дээрээс орж ирээд манайд төгрөгөөр авна.

Лхагваа, чи үүнийг гүйцэд хариулаадхаач. Ажлын хэсгийн 3 дугаар микрофон. Гэхдээ энэ Батжаргал гишүүн логик юм асуугаад байна шүү дээ. Та нарын бичсэн юм чинь яг тэгж ойлгогдохоор байна шүү.

Б.Лхагвасүрэн: Тэгээд яах вэ, бас энэ саналыг бичиж байх явцад бид хэд бас Оюу толгойн алтыг авч болох уу гэдэг талаасаа бас ярьж байсан юм.

Ч.Хүрэлбаатар: Үгүй ээ, үгүй. Оюу толгой биш ээ, чи энэ бичсэн юм аа хараадхаач.

Гадаад зах зээл дээрээс алт худалдан авчаж байна шүү дээ. Гадаад, дотоодын зах зээл дээрээс. Гадаад зах зээл дээрээсээ яаж авах юм бэ л гэж асууж байна.

Б.Лхагвасүрэн: Оюу толгойн алт нь өөрөө манай ингээд баяжмал хэлбэрээр ингээд нунтаг хэлбэрээр гараад явчаж байгаа юм. Дараа нь баяжуулах үйлдвэр дээрээ зэс, алт мөнгө бол салж байгаа. Тэгэхээр тэр хэсгийнх нь алтыг одоо тэр чинь гадаадад гарчихсан, гадаад зах дээр гарчихсан гэсэн үг шүү дээ, тэр алт чинь. Түүнийг нь буцааж Монгол руу бас оруулж ирэх боломж юу байна аа гэдгээр. Гэхдээ Монголд бид нар түүнийг нь төгрөгөөр авна аа л гэж л. Оюу толгойтой бол бас тодорхой хэмжээгээр энэ талаар ярьж байгаа юм.

Ч.Хүрэлбаатар: Тэгвэл гадаад зах зээл гэдэг нь Оюу толгойн алт юм байна шүү дээ, мөн үү. Ажлын хэсгийн 3 дугаар микрофон.

Б.Лхагвасүрэн: Ер нь бас тэгж ойлгож болно.

Ч.Хүрэлбаатар: Тэгвэл түүнийгээ тэгээд шууд биччих хэрэгтэй шүү дээ.

Б.Лхагвасүрэн: Тэгэхдээ яах вэ, одоо энэ бол одоо нөгөө баяжмал хэлбэрээр гараад бас яаж процесс нь яаж явагдах нь бас тодорхой биш байгаа учраас шууд Оюу толгой гэж бас хэлж шууд бичихээсээ бас

Ч.Хүрэлбаатар: Гадаадын зах зээл дээрээс алт худалдаж авна аа гээд биччихээр чинь энэ 5 хувь илүү төлөөд өөрсдөө ингээд зүгээр юу янз бүрийн тийм манифляц хийх юм, орон зай үүсгэх гэж байгаа юм биш биз гэж асуугаад байна шүү дээ. Маш эрүүл юм асуугаад байна шүү дээ. Жавхлан сайд.

Б.Жавхлан: Одоо бид нар богино хугацаанд алт худалдаж авахын тулд үндсэндээ цаана нь алт барьж явж байгаа хилийн цаана барьж явж байгаа хүнийг бид нар энд шуналыг нь хөдөлгөж байж л авна шүү дээ. Өөрсдөд нь тийм боломж өгөхгүй болбол наашаа орж ирэхгүй шүү дээ, алт.

Тэгээд үгүй ээ, одоо жишээ нь Оросын холбооны улсад хэрвээ манайхаас хэрвээ тэр бага ханшаар тэндээ арилжаалдаг, тэгээд манайд илүү ашигтай хэдэн санал болгох юм бол наашаа оруулж ирээд төгрөгөөр зарж болно шүү дээ. Үгүй ээ, тэр чинь л гадаад зах зээл шүү дээ, тэгээд.

Ч.Хүрэлбаатар: Наашаа, жишээлбэл Оросын хилээр бол алтыг бариад ороод ирэх юм бол нөгөө мөнгө угаах юу муугаараа бол тэр чинь хязгаартай, 10 мянган доллароос хэтрэх ч үгүй байх. Яах вэ, 9 мянган долларын алтаа барьж орж ирж болох л байна. Гэхдээ энэ үгэн дээр нь болохоор гадаад зах зээл гээд биччихсэн байна шүү дээ. Гадаад зах зээл гэдэг юм бол гадаадад алт зардаг албан ёсны зах зээлийг л хэлж байгаа шүү дээ. Лхагваа Ерөнхийлөгч хариулъя. та нарын бичсэн юмыг чинь л асуугаад байна шүү дээ.

Б.Лхагвасүрэн: Тийм яг зах зээл гэдэг үгээрээ шууд одоо Лондонд байгаа зах юм уу, Америкт байгаа тэр захаас алт авах тухай наана чинь байхгүй учраас хэрвээ үгэн дээр нь бол найруулгаараа сольж болно.

Ч.Хүрэлбаатар: Тэгвэл найруулгыг нь засаарай. Тэгэхгүй болбол Батжаргал гишүүний асуугаад байгаа зүйл бол зөв шүү. Тодруулна гэсэн үү, үгүй юу. Батжаргал гишүүн тодруулъя.

Ж.Батжаргал: Үгүй ээ яах вэ, бид одоо ингээд нөөц бүрдүүлнэ гээд яриад байж болно л доо. Гоё болно. Гэтэл одоо өнөө нэг жоол тушаадаг Лондонгийн биржийнхээ үнээр тушаачихдаг алтнуудаа бид тэр нэг муу хэдэн тооцоонд ороогүй нинжа нараас нэг хэдэн кило алт авахын тулд 20 тонн алтаа 5 хувиар илүү авах гээд байгаа байхгүй юу. Ойлгож байна уу? Одоо бүх байгууллагууд чинь та нарын наад гарсан хууль нь дотор чинь Лондонгийн биржийн үнээс 5 хувиар илүү ав гэсэн, тэгээд одоо наад гэрээтэй бүх алтны уурхайнууд чинь тэгж л өгнө шүү дээ.

Үгүй ээ, үгүй, харин тэгээд ямар ашиг гарах юм, наана чинь. Ямар ч ашиг гарахгүй байна шүү дээ. Нэг муу хэдэн 5, 10 кило алтны төлөө 20 тонн алт авдаг мөнгөө 5 хувиар өсгөчихөөр чинь ямар юмных нь нөөц бүрдүүлэлт байдаг юм энэ чинь.

Ч.Хүрэлбаатар: Жавхлан сайд хариулъя. Тайван хариулцгаагаарай.

Б.Жавхлан: Батжаргал гишүүн ээ, 5 хувийн премиум төлж авснаараа эдийн засгийн хувьд бол төв банк алдагдлаа нэмэгдэнэ, алдагдал нэмэгдэнэ. Харин энэ чинь бодлогын зардал гаргаж байгаа юм. Гадаад валютынхаа нөөцийг богино хугацаанд нэмэгдүүлэх, бид нар тэр одоо тушаах гэж байсан алт гудсан доор чинь байсан алт гэдгийг ялгах, тэгж суух хооронд энэ гадаад валютын нөөц маань бидэнд маш хүчтэй шок өгч байна. Эдийн засгийн ашиг гэхээсээ илүү бидэнд валют нь хэрэгтэй байгаа учраас түүнийг нэгдүгээрт тавьж, яг ийм хүнд үед ийм одоо арга ядсан л арга хэмжээ авч байгаа юм.

Эдийн засгийн ашиг харах юм бол энэ эдийн засгийн ашиггүй, яг баланс дээр гардаг ашиг харах юм бол энэ ямар ч ашиггүй. Гадаад валютынхаа нөөцийг нэмэгдүүлнэ, богино хугацаанд арга хэмжээ авч байгаа.

Ч.Хүрэлбаатар: Микрофондоо. Батжаргал гишүүний микрофоныг өгье. Сонсогдож байна л даа, тэгэхдээ Батжаргал гишүүн ээ, микрофондоо.

Ж.Батжаргал: Юу гэж энэ чинь даан ч дээ. Хил гааль бүх юм чинь хаалттай байхад 50 хувь нь тушаагдаад, 50 хувь нь тушаагдахгүй байна гэж байх юм. Тэгэхээр зэрэг наад чинь балай юм байхгүй юу. Хорин 20 тонн алт зүгээр тушаачхаад байгаа улсуудыг та нар 5 хувиар илүү авна аа гэж хэлэхээр чинь зэрэг нэг муу 10 кило алт цуглуулж ирэхийн төлөө тийм юм ярихаар чинь ямар өөдтэй юм болдог юм энэ чинь. Далд эдийн засагчийн гэдэг юм уу, далд алт чинь хэдэн хувь байгаа юм гэдгээ яг тодорхой баримжаалсан бол, магадгүй тэр тоо нь өндөр байгаа бол ийм арга хэмжээ аваад алт цуглуулж болох юмсанж. Гэтэл хариугүй хувьтай байгаа юман дээр бид 20 тонн алтаа зүгээр үнээр нь металлынхаа үнээр авчихдаг юмыг 5 хувь илүү төлөөд авахаар чинь энэ чинь балай их мөнгө гардаг юм байх биз дээ энэ чинь.

Би бол ойлгохгүй юм байна, ерөөсөө яаж ойлгодог эдийн засагч нар юм.

Ч.Хүрэлбаатар: Ер нь бол ингэнэ л дээ. Одоо зүгээр товчхондоо хэлэхэд. Лхагваа Ерөнхийлөгч бол 24 тонн алт авна, 1 тэрбум доллар гэсэн. 1 тэрбум долларын 5 хувь нь хэд үү, 50 сая доллар уу. 50 сая доллар яг үүгээр хийгдээд ингэх юм бол 50 сая долларын алдагдлыг Монголбанк яг баланс дээрээ авна. Тийм. Ийм ийм зүйл, гэхдээ үүнээс гарах одоо эдийн засгийн бусад давуу нөхцөл байдал нь бол нөөцөө нэмэгдүүлж ханшаа одоо тогтвортой байлгахад нөлөөлнө өө гэж үзэж ийм арга хэмжээг 8 сарын хугацаанд хэрэгжүүлэхээр Засгийн газар, Монголбанк 5 хамтарч оруулж ирж байна л даа. Яг бичилтээ хийвэл 50 сая долларын алдагдал Монголбанк дээр бичигдэнэ.

Өнөрболор гишүүн асуулт асууя.

Д.Өнөрболор: Энэ хуулийн төслийн 5 дугаар зүйл дээр Монголбанкнаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ гээд энэ зүйл дээр хуулийн төслийн энэ 5.1-ийг үзэхээр Монголбанктай Монголбанк хамтрах гээд байгаад байгаа юм уу гэж ойлгогдоод байх юм. Хуулийн төсөл байна уу? Тийм 5.1 дээр. 5.1 дээр Монголбанктай Монголбанк өөрөө хамтрах гээд байна уу гэж бол ойлгогдох гээд байна л даа. Тэгээд энэ урьдчилгаа санхүүжилт тийм эргэлтийн хөрөнгөнд шаардлагатай, энэ санхүүжилтийг банкаар дамжуулж бол олгоно оо гэсэн байна. Тэгэхээр үүнийг яг юу гэж ойлгох вэ? Яг эх үүсвэрийг нь одоо хаанаас шийдэх юм бэ? Хэнд яаж олгох юм бэ? Банк гээд байгаа нь ер нь яг аль банк вэ, Монголбанк юм уу? Арилжааны банк юм уу тийм ээ?

Нөгөө бас нэг асуудал нь энэ хуулийн төсөлд бас нэг тодорхойгүй, ойлгомжгүй нэг хэсэг нь бол энэ хуулийн төсөлд онцгой журмаар шийднэ ээ гээд байгаа юм. Тэгээд энэ онцгой журам гэж яг юуг хэлж байгаа юм бэ? Яг ямар арга замаар яаж хэрэгжүүлэх гэдгийг тодорхой хүрээ хязгаартай авч яг энэ авч үзэж ер нь нэр томьёоны энэ тодорхойлолтыг хийх шаардлагатай юм уу? гэж бол харагдаж байна.

Нөгөөтээгүүр энэ импортын барааны гаалийн татварыг хөнгөлж чөлөөлөх эрхийг Засгийн газар авч байгаа юм байна. Тэгэхээр өнгөрсөн жил бол энэ гаднаас одоо үр тариа их хэмжээгээр авч дотоодын улаан буудайн үнийг унагаж бас тариаланчдыг хохироосон гээд нэлээн их одоо шүүмжлэл одоо бий болсон. Тэгэхээр үүнийг ер нь хэрхэн яаж, ямар шалгуураар одоо чөлөөлөх гэж байгаа вэ? Яг гурил дээр импортын татварыг одоо хөнгөлж чөлөөлнө гэсэн үг юм уу?

Ч.Хүрэлбаатар: Уучлаарай, хэн хариулах вэ. Лхагваа ажлын хэсгийн 3 дугаар микрофон.

Б.Лхагвасүрэн: Өнөрболор гишүүний асуулт дээр бол банктai холбоотой эсэхийг. Тэгэхээр банк дээр одоо төв банкны үнэт цаасан дээр байршсан 5 их наяд төгрөг байна. Энэ бол одоо ингээд чөлөөтэй эх үүсвэр гэсэн үг. Тэгэхээр энэ эх үүсвэрийг энэ 3 бүтээгдэхүүнд л зориулж ашиглах гэж байгаа. Энэ 3 бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх. Тэгэхээр бол яг л тийм хэллэгээр орж байгаа. Яах вэ, өмнө нь бол Монголбанкаар банкаар дамжуулна гэдэг байсныг нь, сүүлд бол ажлын хэсэг дээрээ засаад банкны эх үүсвэрийг ашиглана гэдгээр ингээд явж байгаа. Тэгэхээр бол одоо банкны эх үүсвэрийг л ашиглана.

Зарим нэг Монголбанкны өөрийнх нь хэрэгжүүлдэг бас журам дээр тодорхой хэмжээний бас өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага гарч байгаа. Яагаад гэвэл одоо энэ нөөцийг бүрдүүлж байгаа компаниудын хувьд барьцаа хөрөнгө нь дутагдах ч юм уу, эс үгүй бол одоо нэг банк дээр байгаа нөгөө зээлийн лимит хэтэрдэг одоо өөрийн хөрөнгөнөөс нь хэтрэх ч юм уу ийм зүйлүүд дээр тодорхой хэмжээ дээр нь бол энэ журмаар хөнгөлөлт үзүүлэх, илүү гарсан дээр нь Засгийн газрын баталгаа гаргах ч юм уу, ийм онцгой арга хэмжээг авч хэрэгжүүлнэ ээ л гэж байгаа юм.

Ч.Хүрэлбаатар: Тодруулъя, Өнөрболор гишүүн. Хүнс, хөдөө аж ахуйн яам. Мэндсайхан сайд хариулаарай.

3.Мэндсайхан: Өнөрболор гишүүний асуултад хариулъя. Энэ гааль татварын Засгийн газрын эрхийг нь авч байгаа нь түрүүний яриад байгаа хүнсний гол нэрийн бүтээгдэхүүнүүд дээр хэрвээ энэ чинь нэг 5 хувь гээд шууд заачихсан байгаа шүү дээ. Тэгэхээр одоо 5 хүртэл ч гэдэг юм уу ийм байдлаар зохицуулалтыг нь авъя гэж байгаа юм. Тэгэхээр одоо гол нэрийн үндэсний бүтээгдэхүүнүүд болох элсэн чихэр ч гэдэг юм уу, будаа ургамлын тосон дээр хэрвээ одоо зохицуулалт хийх шаардлагатай бол тэр дотор нь зохицуулаад явъя аа л гэдэг ийм байдлаар оруулж ирж байгаа. Энэ гурил, махан дээр гол нь бид нар нийлүүлэлтийг нэмэгдүүлэх замаар үнийг тогтвортой байлгая, энэ чиглэлээр бизнес эрхэлдэг буюу тариалалт эрхэлдэг аж ахуйн нэгжүүддээ эргэлтийн хөрөнгөөр дэмжье ээ гэдэг ийм бодлог оо. Тэгэхээр ямар нэгэн гурил импортоор оруулж ирэх асуудалд үнэ хөнгөлөлт үзүүлэх асуудал байхгүй ээ.

Ч.Хүрэлбаатар: Энэ дээр ийм байгаа. Би энэ зүгээр ажлын хэсгийн саналыг хэлчихье. Энэ импортын татвартай холбоотой зүйл энэ цэвэр Их Хурлын мэдлийн асуудал юм байгаа юм. Тэгэхээр яг энэ хууль дээрээс бид нар энэ импортыг нь аваад хаячхаж байгаа юм. Харин дагалдаж байгаа тэр нийт бүтээгдэхүүн, эрчим хүч дээр тавигдах тэр импортын татварыг одоо зохицуулах эрхийг нь Засгийн газарт өгье гэдэг дагалдах хуулийг нь бол дэмжчихэж байгаа юм.

Төсвийн тодотголдоо тэр дагалдуулаад тэр тооцоогоо хийж байгаад яг авах гэж байгаа, одоо хөнгөлүүлэх гэж байгаа нэг жилийн хугацаанд хөнгөлүүлэх гэж байгаа импортын барааныхаа нэр төрлийг бичиж төсвийнхөө тодотголыг дагуулж өргүүлэхээр энэ дээр зохицуулж хийж байгаа бас тийм дураараа өөрчлөөд байдаг татварууд ч бас биш. Тийм учраас үүнийг тийм байхаар ажлын хэсэг дээр ажиллаад үүнийг нь хасчихсан байгаа шүү. Хасаад төсвийн тодотгол дээр зарим нь орж ирнэ,

зарим нь тэр дагалдсан тогтоолоор хуулиар өөрчлөгдөөд явна аа гэсэн юм байгаа. Тэгэхээр энэ дээр хаа хамаагүй ямар ч бараа бүтээгдэхүүний импортын татваруудыг өөрчлөөд байна гэсэн бас ойлголт бол бас биш ээ гэдгийг хэлье. Ийм байдлаар өөрчилчихсэн юм. Би нөгөө өөрөө ажлын хэсэг дээр А, Б-гүй суучихсан учраас юугаа бол мэдээд байгаа юм. Тийм учраас асуулт асуухгүй байгаа юм.

Одоо 6 дугаар зүйл. Хуулийн төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу?

6.1.3 дээр үү? Хасаж байгаа юм. 6-г асуучихсан шүү дээ.

6 зөв, зөв нэрсээ өгье. Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Засгийн газар, Монголбанканд бас яг энэ тал дээр нэг өөрийнхөө бодлыг хэлье гэж бодож байна. Тэгэхээр бодлогын хүүг яаралтай 13 хувьд хүргэх хэрэгтэй, тэгж байж энэ зах зээл дээр байгаа бэлэн мөнгийг татах замаар эрэлт нийлэлтүүдийг зохицуулах ийм нөхцөл байдал руу очно гэж үзэж байгаа. Тэгээд үүний хажуугаар бол ханшийн асуудал байгаа. Тэр ханшийн асуудал дээр Засгийн газар яаралтай Оюу толгойтой хэлэлцээр хийж татварын урьдчилгаа 1 тэрбум доллар авах хэрэгтэй. Дээрээс нь Эрдэнэтийн бараа бүтээгдэхүүнийг урьдчилсан борлуулалт хийгээд тэндээсээ нэг 500 сая доллар татах хэрэгтэй. Нэг сарын дотор иймэрхүү ажил хийх юм уу, энэ 13 хувь болгоод, одоо энэ саяын 2 ажлыг хийх юм бол ханшийг тогтвортой хэмжээнд барьж чадна аа гэж би харж байгаа.

Тэгээд энэ хоорондоо Засгийн газар 2 ажлыг яаралтай хийх хэрэгтэй. Ирэх оны Монгол, Орос, Хятадын төмөр замын төлөвлөгөөнд тэр өнөөдөр байгаа 8 транзит, 6 Монголын ачаа ачиж байгаа үүнийг одоо энэ 6 транзит, 8 Монголын бараа бүтээгдэхүүн ачих ийм хэлэлцээрийг хийх хэрэгтэй байж байна. Гадаад хэргийн сайд энэ дээр анхаараарай гэж хэлье.

2 дахь асуудал нь бол энэ Таван толгойн нүүрсний экспорт байгаа. Энэ нүүрсний экспорт Гашуун сухайт дээр бол гамшиг болгож байна. Тэнд хариуцлагагүй байдал нүүрлэж байна. Авлига, хээл хахууль хэтэрч байна. Улаанбаатар хотын төвөөс Найрамдал орох энэ хэмжээний газар 25 километр газарт 85 сая төгрөгөөр тээвэр хийж байна. Өдөрт 2 зуухан машин гаргаж тийм блок үүсгэж байгаад одоо цуваа юу гэдэг юм очер үүсгэж байгаад албан тушаалтнууд эндээс мөнгө хулгайлж байна, Хятадын компаниудтай нийлж. Гэтэл цаанаас нь Баяннуурын засаг захиргаа одоо нурмаг ачаа байсан чинь одоо задгайгаар ачсан ч болно. Хамгийн гол нь та нарын тэр цаад талдаа байгаа тэр барааны үнэд нөлөөлөөд байгаа тэр тээврийнхээ асуудлыг шийдвэрлээч ээ гэж. Тэгвэл мянгыг ч хамаагүй гаргана гэж байгаа шүү дээ. Энэ дээр хариуцлагатай бай л даа. Тэр бөмбөлөг гэдэг юманд нь ордог, бөмбөлгөөс нь цалин багатай цагдаа хэдхэн төгрөг аваад тэр одоо цагдаа ч байхаа больсон гэсэн нэг хамгаалалтын алба яадаг юм уу яадаг юм цалингүй нөхөр нэг хэдхэн төгрөг аваад тэр бөмбөлөгт байгаа хүнийг гаргаад явуулчихдаг, хот руу явуулдаг.

Хотод явж байгаад нөгөө нөхөр нь нэг эмчээс “сөрөг” гэсэн бичиг авч очдог. Тэгээд тийшээ цаашаа гардаг, оноос хойш 100 ширхэг 100 гаруй хүн одоо тэндээс өвчтэй гэж гарлаа шүү дээ. Тэнд хангалттай цалинг нь Засгийн газар өг өө, 200 албан хаагч ажиллаж байгаа. Нэгэнд нь 5 сая төгрөг өг, сайн шах, өдөр шөнөгүй ажиллуул.

Тэгж өөрсдөө сахилга хариуцлагаа нэмэгдүүлж байж тэндхийн экспортын үйл ажиллагааг илүү сайн түвшинд аваачна гэж үзэж байгаа шүү дээ. Ингэж орлогоо нэмэгдүүлэх ажлыг сайн хийхгүй болбол энэ энэ одоо хямрал чинь тийм амархан шийдэгдэхгүй ээ. Тэгээд бүх юмыг дайн руу чихчээд л ковид руу чихчээд, өөрсдөө тэнд хариуцлагагүй байдалтай байгаад янз янзын хулгай дээрэм хийгээд хоёр зуухан машин гаргаж байгаад өөрсдөө хулгайлдаг ийм зүйл рүү яваад байх юм болбол энэ хямралын асуудал чинь цэг болж чадахгүй. Энэ дээр хариуцлагатай ажиллаарай гэж хэлье.

Ч.Хүрэлбаатар: Санал хэллээ. Булгантуяа гишүүн асуулт асууяаа.

Х.Булгантуяа: Та сая манай ажлын хэсэг 10.30-аас цуглаад бид нар бараг 2 цаг гаруй үүн дээр ажилласан л даа. Монголбанкнаас дэд ерөнхийлөгч Энхтайван дэд ерөнхийлөгч ирсэн. Засгийн газраас Сангийн яамнаас бол хүн ирээгүй. Тэгээд бид нар ингээд энэ холбогдох зарим нэг зүйл заалтуудыг нь яг ямар учир агуулгаар оруулсан юм бэ? Зарим дээр нь бид нар бас хасъя гэдэг санал энэ тэр гаргахад үнэнийг хэлэхэд ингээд асуух, тодруулах хүн байхгүй учраас ажлын хэсэг дээр бид нар одоо өөрөө өөрсдийнхөө ойлголтоор л ингээд л санал хураалт хийгээд л явсан.

Бид нар 6.1.2-ыг бол энэ хөнгөлөлттэй зээл олгоход шаардагдах хүүгийн татаасыг одоо төсвийн тодотгол орж ирнэ. Үүн дээр төсвийн тодотгол дээр бүр үүнийг нарийн зааж өгөөд батлуулсан нь зүйтэй гэж үзэж байгаа.

6.1.4-ийг төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан хязгаарын хүрээнд энэхүү хуульд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын үнэт цаас, баталгаа гаргах гэснийг тухайн жилийн төсөвт одоо ингээд баталж өгсөн юуны хүрээнд гэж бид одоо үүнийг төсөвтэйгөө уях нь зүйтэй юм аа гээд үүнийг бид нар бас хассан.

6.1.5-ыг энэ Монголбанкны пассив актив хөрөнгөөс хэрвээ хэтэрсэн тохиолдолд энэ хуулийг хэрэгжүүлэх явцад үнэт цаас гаргах замаар үг зөрөөг нь нөхнө өө гэдгийг нь энэ угаасаа төв банкны тухай хууль дээр байгаа гээд энэ Засгийн газрын хүлээх үүрэг. Монголбанкны дэд ерөнхийлөгч нь бол үүнийг нь дэмжсэн. Ойлгохдоо бол уг нь бол үүнийг давхар Засгийн газрыг үүрэгжүүлж байгаа гэсэн. Тэртээ тэргүй хуульд нь байгаа юм чинь хасхад бол зүгээр ээ гэсэн. Тэгээд бид нар ингээд манай ажлын хэсэг дээр бусад хуулиуд дээр байгаа, эс үгүй бол бусад хуулиудтай жаахан зөрчилдөж байгаа ийм зүйлүүдийг нь ингээд хасаад явсан. Тэгээд үүн дээр 6.1.2 ч яах вэ одоо төсвийн тодотголоор ингээд ороод ирэх байх.

6.1.4-ийн хувьд ийм байдлаар одоо ингээд бид нар хасъя гэсэн шийдвэр гаргаад явж байгаа. Энэ төсөл хэн хууль хэрэгжихэд ямар нэгэн сөрөг нөлөө тийм зүйл байх уу? Жавхлан сайд аа.

Ч.Хүрэлбаатар: Жавхлан сайд.

Б.Жавхлан: Сөрөг нөлөө гарна шүү. Өглөө одоо бас нөгөө төсвийн тодотголтой холбоотойгоор вакумжаад бас ингээд сууж байсан л даа. Тэгээд ирье гэтэл тарчихсан байсан шүү, уучлаарай.

6.1.4 дээр болбол юу гарна аа. Хүндрэл гарна шүү. Энэ заалт хасчих юм бол. Би түрүүн хариултдаа бас дурдсан. Бид төсвийн хуулийнхаа хүрээнд гаргаж болох Засгийн газрын үнэт цаас, баталгаа маань зөвхөн одоо, жишээ нь үнэт цаас болбол улирлын шинжтэй төсвийн орлого тасалдвал одоо түүнийг одоо нөхөх зорилгоор гаргадаг. Засгийн газрын жишээ нь баталгаа гэх юм бол бид одоо үйл ажиллагааны чиглэл мөрийн хөтөлбөрт орсон ч гэдэг юм уу энэ жил одоо хийгдэхээр төлөвлөгдсөн томоохон төсөл хөтөлбөрүүд дээр баталгаа гаргах орон зай ингээд Засгийн газар шийдээд явдаг. Тэгэхээр яг энэ хуулийнхаа хүрээнд нөгөө шатахуун, мах, гурилынхаа хувьд зөвхөн хэрэглэх ийм зорилготой учраас тэр нөгөө яг одоо байгаа суурь хуулиудаар энд зарцуулах боломжгүй учраас л одоо энэ хуулиараа боломжийг нь нээж өгье л гэж ингэж оруулж байгаа юм. Тэгээд энэ маань байхгүй болчих юм бол бас энэ хуулийн гол хэрэгслүүдийн маань нэг нь байхгүй болчих учраас үүнийг ажлын хэсэг дээр нь эргэж хараач ээ гэсэн хүсэлт байна аа. Тэгээд үүнийг нэг хараач ээ.

6.1.2-ын хувьд төсвийн тодотголыг хараахан бэлдээгүй байна. Ер нь өргөн барьж таарах байх. Зүгээр энэ хооронд зүгээр хугацаа алдах вий. Хууль маань ерөөсөө энэ долоо хоногт батлагдаад шууд хэрэгжээд эхлэх учраас төсвийн тодотголоо бид нар хүлээхээр, магадгүй дахиад ер нь цаг хугацааны хувьд дараа долоо хоногт, магадгүй ингээд 14 хоногийн бас алдагдал юм байгаа учраас энэ цаг хугацааны эрсдэл байгаа шүү, тийм. Түүнийг бас нэг эргэж хараач ээ л гэе.

Ч.Хүрэлбаатар: Булгантуяа гишүүн тодруулъя.

Х.Булгантуяа: Ажлын хэсэг дээр Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас төлөөлөл байсан, бид нар ялангуяа энэ хүнсний 2 нэр төрлийн бараа бүтээгдэхүүний үнийг одоо үнийг нь хомсдолыг нь арилгахын тулд юу хийх юм бэ гэхэд ерөнхийдөө бол энэ намар гурил худалдан авах компаниудаас, дээрээс нь нэмээд мах, махны энэ бойны үеэр ерөнхийдөө бол энэ санхүүжилт нь гарна аа гэж бид нар ойлгож байгаа шүү дээ. Тэгэхээр яг өнөө маргаашдаа бол шууд энэ чинь батлагдсан даруйдаа санхүүжилт нь маргааш нөгөөдрөөс нь авхуулаад гараад явна аа бол биш юм байна лээ шүү дээ, Мэндсайхан сайд аа. Би тэгж ойлгож байгаа, зөв үү? Танай ажлын хэсэг чинь газрын чинь дарга бол бид нарт бол тэгж тайлбарласан шүү.

Одоо энэ хаврын тариалалт дээр байдаг юм уу хэрэгтэй байгаа түүнийг нь та нар 3 хувийн хүүтэй 100 тэрбум төгрөгийн нөгөө 10 их наядын хөтөлбөрийн чинь хүрээнд бол угаасаа санхүүжигдээд явж байгаа. Тэгэхээр яах вэ, үүнийг угаасаа ингээд батлаад өгвөл энэ нь намар л ерөнхийдөө бол энэ санхүүжилт чинь хэрэгжих юм байна аа.

Тэр бензин шатахуун бол харин шууд, бензинийг бол шууд хэрэгжээд явах юм байна. Хүнс, хөдөө аж ахуйнх бол ... /минут дуусав/

Ч.Хүрэлбаатар: Мэндсайхан сайд хариулъя. Наана нь би нэг юм тодруулаад хэлчихье. Жавхлан сайд аа, 6.1.2, 6.1.4 хоёр бол хоёулаа төсвийн харилцаанууд, тэгээд энэ Ардчилсан намынхны хийсэн үнэ тогтворжуулах хөтөлбөр бол нөгөө куази физикал гээд төсвөөс гадуурх үйл ажиллагаа гээд аудитын дүгнэлтэд орчихсон учраас бид нар энэ төсвөөс гадуурх үйл ажиллагаатай холбоотой болгох энэ 2 заалтыг нь бол хасаж байгаа. Тэгэхгүй бол энэ өөрөө хууль зөрчсөн үйл ажиллагаатай болоод явж байгаа юм.

Мэндсайхан сайд.

3.Мэндсайхан: Хууль батлагдан гарах юм бол үр дүн нь шууд хэрэгжээд явна аа. Энэ хаврын тариалалтаас эхлээд явна. Бид нар бордоо, шатахуун гээд энэ хаврын тариалалтад шаардлагатай бүх зүйлүүд энэ хуулийн үйлчлэлд ороод л дэмжлэг явагдаад явна гэсэн үг.

Намрын ургац хураалт хүртэл бид нар хэдийгээр одоо үйлдвэр, дотоодын нөөц бол намрын ургац хүртэл байгаа. Гэхдээ үйлдвэрүүд маань эргэлтийн өрийг зээлээ судлах, нөгөө талдаа мах бэлтгэлийн ажил чинь 7 сарын 01 гээд л эхэлнэ. Бид нар мал мах нядалгааны үеэр эхэлдэг асуудал биш байхгүй юу. Зээлийн хөрөнгө судлагдлаа, 6 сараас л эхлээд л ногоо гарлаа. Малчид отор туувраа бэлтгэнэ, мал махаа бэлдэнэ энэ чинь зүгээр мал нядлах хугацаа нь өвлийн улирал буюу 10-11 сарын хугацаанд болохоос биш мах бэлтгэлийн хугацаа гэдэг чинь 6 сараас эхлээд л явчхаж байгаа шүү дээ. Тэгэхээр ирэх жилийн нөөцөө бэлтгэхийн тулд бид нарын бэлдсэн энэ жилийн нөөц бол 7 сарын 01 хүртэл явна. Тэгээд бид нар энэ зуны нойтон махтайгаа залгачихна. Тэндээс эхлээд мах бэлтгэлийн ажил чинь явна. Аж ахуйн нэгжүүд маань мал махаа бэлдэнэ, 11 сар гэхэд нядалгаандаа оруулаад ... /минут дуусав/

Ч.Хүрэлбаатар: Пүрэвдорж гишүүн махны үнэ өсөхгүй гэнэ ээ. Жавхлан сайд.

Б.Жавхлан: Харин тийм. Тэр куази физикал асуудал бол төв банк дээр акт тогтоогдсон, акт тавьсан. Мөн олон улсын валютын сан хөтөлбөрт орж байх үед байн байн сануулдаг асуудал. Тэгэхдээ энэ удаа энэ хууль дээр маань энэ 6 дугаар зүйл нь Засгийн газрын авч хэрэгжүүлэх арга хэмжээ учраас Засгийн газар өөрөө одоо төсвийн зохицуулалт хийх гэж байгаа арга хэмжээ учраас энэ дээр ажлын хэсэг бас нэг эргэж хараач ээ. Ялангуяа тэр яг Засгийн газрын баталгаан дээр бол жишээ нь шатахууны татан авалт дээр импортлогч нэр дээр шаардлагатай нөөцөө татаж авахад нь зээлийн эх үүсвэр нь дутмаг байгаа учраас тэр нөгөө хуулийн хязгаарлалтаас давсан эсэх дээр нь Засгийн газар баталгаа гаргаж өгч, хангалттай нөөцийг нь татуулах л ийм л хэрэгсэл гаргах гээд байгаа юм. Тэгэхээр түүнээс биш яг төв банкаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол энэ огт биш. Импортлогч нар банкнаас зээл авна, шаардлагатай дутмаг тэр хэсэг дээр нь Засгийн газраас одоо шууд .../минут дуусав/

Ч.Хүрэлбаатар: Харин тийм. Тэгэхээр энэ төсвийн тодотголоо л яаралтай өргөчих. Тэгээд 6.1.2, 6.1.4 дээрх зүйлүүдээ та нар төсөв дээрээ холбогдуулаад дагуулаад өгчих. Тэгэхгүй болбол энэ зарчим нь буруу болчих гээд байгаа байхгүй юу. Засгийн газар төсөв дээр биш өөр ямар нэгэн хуулиар үнэт цаас гаргах, баталгаа өгөх ийм юм явагдаад байна гэж, өөрөө төсвөөс гадуурх юм шүү дээ.

6 дугаар зүйл байхгүй. Одоо жоохон шуурхай явна аа. Пүрэвдорж гишүүн ядрах шиг боллоо.

Хуулийн төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Байхгүй ээ, баярлалаа.

Хуулийн төслийн 8 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Тэмүүлэн гишүүнээр тасалъя. Батжаргал гишүүн асууя.

Ж.Батжаргал: Энэ хуулийн зорилго өөрөө үнийн өсөлт хомсдолоос урьдчилан сэргийлэх тухай л асуудал яригдаад байгаа юм. Тэгэхээр нөөц нэмэгдүүлэлтийн тухай л асуудал байгаа л даа. Тэгэхээр манай Хөдөө аж ахуйн яам мах, гурилынхаа нөөцийг нэмэгдүүлэх чиглэл дээр өнөө махаа бол болдог байх гэж бодоод байна аа. Гурил дээрээ бол гурилаа бэлддэг, будаагаа нэмэгдүүлэх тухай л асуудал байгаа. Үүнийгээ нэлээн сайн анхаарч, энэ жил хаврын тариалалт руугаа их анхаарах ёстой юм аа. Үүнийг ер нь нэлээн сайн бодохгүй бол болохгүй юм байна гэж.

2 дахь миний хэлмээр байгаа зүйл бол өөрийнхөө дотоодын хэрэгцээ, нөөц, бүх юмаа тооцож үзээд мах, гурил 2 дээр экспортын шинэ одоо жим гаргах л хэрэгтэй байна, энэ хүнд цаг үед. Би бол гурилан дээр бололцоо байгаа гэж хараад байгаа шүү дээ. Өнгөрсөн жил ургац хураахаас өмнө 150 мянган тонн улаан буудай элеваторууд үлдэгдлээр байсан, дөрвөн зуун хэдэн мянган тонн будаа шинээр татаж ургацаасаа авсан гээд бодохоор зэрэг бараг 2 жилийн нөөц бүрдүүлэлт шахуу хийчихсэн гэж би бол бараг ойлгох гээд байгаа хүн шүү дээ, энэ чинь физиологийн норм нь бараг 8, 9 хүүхэдтэй боорцог хийж иддэг байх үеийн гурилын норм одоо хэр нь өөрчлөгдөөгүй яваад байгаа эд шүү дээ. Тэгэхээр бид нарын хэрэглээнд их том өөрчлөлт орчихсон ийм л зүйл. Тэгээд бодохоор гурилын нөөц нэлээн байх юм байна гэж хараад байгаа юм. Тэгэхээр гурилыг нэг жоохон гадагш нь гаргах жоохон жим хиймээр байгаа юм.

Махыг нэг янз бүрийн хил, гаалийн хязгаарлалтууд авч чадахгүй хэвтээд байгаа юмыг, энэ нэг хямралт байдал гэдэг юм уу энэ гадаад нөхцөл байдлаас хамааралтай хүнсний хомсдолыг далимдуулаад нэг жоохон гадагш нь гаргачихдаг шинэ зах зээлийн жим үүсгэчихмээр байх юм. Тэгвэл энэ хүнд цаг үед бий болгосон энэ жимээр ирэх он жилүүдэд бас нэг тийм экспортын шинэ зам болоод өргөжчих юм болов уу л гэж бодоод байх юм. Би үүнийг энэ 6.1.1 дээр л хиймээр байгаа юм. Үгүй ээ, юуны 8.1.1 дээр.

Тэр хангамж нөөцөө барьчихалгүйхэн шиг байж болох давсан нөөцөө гадагш нь жоохон гаргачихмаар л байна. Мах, гурил 2 дээр бол.

Ч.Хүрэлбаатар: Арай өөр хуулиар зохицуулаад явъя, яг энэ дээр биш.

Ж.Батжаргал: Энэ чинь л харин зөв юм биш үү? Би тэгж л бодоод байгаа шүү дээ.

Ч.Хүрэлбаатар: Энэ дотоодынхоо тийм өсөлтийг барих гэж байгаа юм. Экспорт руу гаргаад эхэлбэл үнэ нь угаасаа ингээд дээшээ яваад эхэлнэ шүү дээ.

Гэхдээ хариулъя.

Ж.Батжаргал: Үгүй ээ, үгүй, тэгээд л яриад байвал зөндөө юм яриад байж болно л доо. Хэн ч тэгээд яриад байж чадна. Ер нь байж болох хувилбар нь энэ байхгүй юу. Бид нөөц гэдэг юмыг бас зөв тооцох ёстой шүү дээ.

Ч.Хүрэлбаатар: Мэндсайхан сайд хариулъя.

3.Мэндсайхан: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Энэ бид нар өөрсдөө үүнийгээ шийдээд л явж байгаа. Одоо энэ 8.1 дээр чинь хомсдол үүсэхээс сэргийлээд экспортлох хүнсний тоо, төрөлт хэмжээг тухайн үрд нь тогтоож мөрдүүлэх гэдэг. Хэрвээ бид нарт хомсдол үүсэхгүй бол бид нар экспортоо нээгээд л явна шүү дээ. Нэмэгдүүлээд л явна. Энэ чинь гол нь үнийн өсөлтөд мах, гурил хоёрын чинь инфляцад нөлөөлж байгаа нөлөөлөл их өндөр байгаад байна. Тэгэхээр нийлүүлэлтээ барьж дотоодын үнийн ханшаа тогтвортой байлгая гэдэг хууль дээр экспортоо нэмэгдүүлнэ ээ гээд орчихоор бид нар экспортоо дагаад л бид нар дотоодын үнээ өсгөөд л явна гэсэн үг шүү дээ. Мах бэлтгэлийн үнэ өмнө, та өөрөө мэдэж л байгаа. Тэгэхээр энэ зохицуулах эрхийг нь өгчихөөр чинь бид нар өөрсдөө хэрвээ нийлүүлэлт хангалттай байна гээд л үзэх юм бол экспортоо нээгээд л явна.

Ч.Хүрэлбаатар: Батжаргал гишүүн тодруулъя.

Ж.Батжаргал: Нэлээн жил нэг иймэрхүү л хариулт өгцгөөгөөд байгаа улсууд байгаа юм. Тэгээд гурил гадагш нь экспортод гаргасан тийм зам мөр байгаа юм уу, үгүй юм уу би дуулаагүй. Мах гаргаад гайгүй явмаар болсон. Өмнөхийн өмнөх сайд нь ч билүү тэглэж хаяад гадагшаа гарахыг нь хориод үнэ унагачихсан эд л байхгүй юу. Үгүй ээ, ер нь яг нарийндаа энэ одоо гурилын үйлдвэрүүдэд гэдэг юм уу, мах бэлтгэн нийлүүлж байгаа аж ахуйн нэгжүүдэд хямд өртөгтэй зээл өгнө гэдэг чинь угаасаа бас л хүний чинь тогтвортой өсгөлтийн л зарчим шүү дээ ер нь бол. Энэ Ардчилсан намын авч хэрэгжүүлсэн тэр үнэ тогтворжуулалтын бодлогын ганц том алдаа юу байсан бэ гэхээр зэрэг манайхтай адил дотоодоосоо хангаж болдог юман дээр биш юман дээр баахан үнэ тогтворжуулалтын бодлого гаргаад замбараагүй өсгөсөн эд байхгүй юу. Цементийн үнийг тогтворжуулна гээд баахан мөнгө өгчихсөн. Барилгын компаниуд нь бүгд Хятадын зах зээл дээр очоод цемент уралдаж худалдаж аваад цементийн үнийг хөөргөдчихсөн, үнэн, тийм юм байхгүй юу.

Ч.Хүрэлбаатар: Тэмүүлэн гишүүн асуулт асууя.

Г.Тэмүүлэн: Хүнсний гол энэ зохицуулалттай холбогдуулаад би бас зүгээр нэг ганц санал хэлэх гэсэн л асуудал байгаад байгаа юм. Ерөөсөө бид нар энэ хямралтай яг хүнд нөхцөл дээр яах вэ, гол нэр төрлийнхөө бараа бүтээгдэхүүн гээд энэ дээрээ зүгээр гурил, махныхаа асуудлыг зохицуулалт хийгээд байгаа юм. Тэгээд би энд манай Хөдөө аж ахуйн яам, Сангийн яам ч гэсэн нэг анхаарах ёстой нэг асуудал байгаад байгаа нь дийлэнх Монгол Улс өөрсдөө хүнснийхээ бараа бүтээгдэхүүний ер нь дийлэнхийг гаднаас авч байгаа, импортын бараа бүтээгдэхүүн. Гэтэл өнөөдөр манай энэ хүнсний тухай хууль маань яг энэ ковидын нөхцөл байдал дунд бол одоо юу гэдэг юм яг энэ хямралтай нөхцөл байдалд хэрэгжүүлэхэд их хүнд болчихоод байгаа юм. Юу болж байна гэхээр импортоор орж ирж байгаа гадаадаас одоо юу гэдэг юм татаж оруулж ирж байгаа хүнсний бараа бүтээгдэхүүн дээр хүнсний тухай хуульд заасны дагуу тухайн тэр орж ирж байгаа бараа бүтээгдэхүүний хугацаа гуравны хоёроосоо дээш хэтэрсэн бол оруулж ирэхгүй ч гэдэг юм уу хориглоно, эсвэл дээр нь мэргэжлийн хяналт, гаалиас нэмэлт торгууль, татвар авна аа гэсэн зүйл байгаад байдаг.

Тэгэхээр өнөөдөр угаасаа хил, гаалийн асуудал ямар байгаа билээ, тээвэр ложистик ямар байгаа билээ, Европоор дамжихгүй байгаад байгаа юм. Тэгэхээр Европоос татаж байгаа бараа бүтээгдэхүүн хүнс гээд аваад үзэхэд Хятадаар дамжаад орж ирэхэд зөвхөн энэ тээвэртээ ложистик дээрээ 5 сарыг алдаж байгаа юм. Дийлэнх хүнсний бараа бүтээгдэхүүн болбол ер нь 12 сарын хугацаатай л байгаа. Гэтэл тал хугацааг нь тээвэр ложистик дээр алдчихсан бараа бүтээгдэхүүн манайд хугацаандаа, бараг хугацаа нь дуусаагүй бараа бүтээгдэхүүн орж ирнэ гэсэн зүйл болбол бараг байхгүй болчихоод байгаа юм аа. Тэгээд нэг одоо юу гэдэг юм 3, 4 сарын үлдэгдэлтэй бараа бүтээгдэхүүн орж ирэнгүүт түүн дээр нь 5, 10 саяын торгууль нэмэгдүүлдэг, дахиад оруулаад ирэх юм бол дахиад нэмэгдээд ингээд явчихдаг, дабльдаад явчихдаг ийм асуудал байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ чинь өөрсдөө бид нар хямралтай нөхцөл байдал дээр бид нар одоо юу гэдэг юм хүнснийхээ бараа бүтээгдэхүүнийг найдвартай хангах асуудал нь 1 дүгээр асуудал болохоос биш, хугацаа нь дуусаагүй ч гэсэн бараа бүтээгдэхүүнүүдийг хориглоод байж болохгүй болчихоод байна аа. Тэгэхээр үүнийг одоо юу гэдэг юм түр горимоор ядаж энэ жилийн хугацаанд оруулж ирэх гэдэг юм уу. Ийм зохицуулалтыг хийвэл бид нар хүнснийхээ хангамжийг эрх биш нэг гайгүй одоо юу гэдэг юм, энэ тээвэр ложистик нь удаан байгаа энэ хугацаан дээр ч гэсэн нэг зохицуулаад оруулаад байж болоод байх гэсэн дүр зураг харагдаад байгаа юм. Тэгэхгүйгээр одоо юу гэдэг юм 12 сард, дээрээс нь та 12 сарын хугацаатай бараа бүтээгдэхүүн дээр бид нар 5, 6 сарын тээвэр юундаа алдаад, ингээд хугацаа нь хэтэрсэн бараа бүтээгдэхүүн ороод ирдэг. Нэмээд торгууль төлөөд явдаг, эргээд иргэд дээр очиж байгаа бараа бүтээгдэхүүн чинь өөрөө өндөр үнэтэй тусаж буугаад байна шүү.

Тэгэхээр манай мэргэжлийн хяналт, гааль, энэ хөдөө аж ахуйн яам энэ дээр анхаараач ээ. Гуравны хоёр гэдэг хугацааг түр горимоор чөлөөлүүлэх гэдэг юм уу яг энэ оныхоо хугацаанд ч гэсэн ядаж нэг түр горимоор оруулах зохицуулалт хийхгүй болбол энэ чинь болохгүй байна шүү л гэдэг зохицуулалтыг хэлээд байгаа юм. Тэгэхээр магадгүй дараагийн одоо энэ дээр одоо оруулж ирдэггүй юм аа гэхэд дараа нь Их Хурлын тогтоолоор гэдэг юм уу нэг тийм зохицуулалт хиймээр л байгаад байгаа юм.

Ч.Хүрэлбаатар: Тэмүүлэн гишүүн санал хэллээ.

Хуулийн төслийн 9 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Булгантуяа гишүүн асууна. Булгантуяа гишүүн.

Х.Булгантуяа: Би Ёндон сайдаас асуух гэсэн юм. Бид нар бас ажлын хэсэг дээр үүнийг бас нэлээн ярьсан юм аа. Энэ хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс өмнөх хугацаанд ашигт малтмалын тухай хуулийн гучин тавын зургаад заасныг зөрчсөн этгээдийг энэ хууль үйлчлэх хугацаанд аливаа хариуцлагаас чөлөөлнө өө гээд. Энэ яах вэ нөгөө тухайн жилдээ олборлосон алтыг тухайн жилдээ тушаана аа гэдэг тийм ээ, өмнө энд тэнд дарсан, алт байвал энэ жил тушааж болно оо гээд ерөнхийдөө хуулийн зохицуулалтыг оруулж өгч байгаа юм байна лээ. Тэгээд бид нар энэ аливаа гэдэг үгнээс нь бас нэлээн жоохон тойрч ярьсан л даа. Яах вэ, танай сая энэ ажлын хэсгийн хурал дээр бол танай энэ бензин шатахууны асуудал хариуцсан газрын дарга чинь газрын албанд байсан яг энэ асуудлыг бол төдийлөн

бас сайн мэдэхгүй байгаад байна лээ. Тэгэхээр өөр үүнтэй холбоотойгоор ямар нэгэн өөр хууль, эрх зүйн факт үүсэх тийм одоо зүйл заалт, зүйл байгаа юу? Та нар тэр бүхнийг бас харж судалсан юм байгаа юу?

Ч.Хүрэлбаатар: Ёндон сайд хариулъя. 2 дугаар микрофон.

Г.Ёндон: Булгантуяа гишүүний асуултад хариулъя. Энд тийм өөр ямар нэгэн юу бол ерөөсөө байхгүй байна, тийм яг үнэндээ яг энэ заалтаар өнөөдрийг хүртэл ямар нэгэн хариуцлага хүлээсэн тийм тохиолдол ч байдаггүй, ер нь бол. Яах вэ, бид нар яг ийм аминист үзүүлж байж л одоо нөгөө алтуудыг гаргаж ир л гэсэн юугаараа үүнийг оруулсан болохоос биш түүнээс өөр ямар нэгэн зүйл бол энэ дээр бол байхгүй.

Ер нь нэлээд аж ахуйн нэгжүүд бол одоо яг энд эд ингээд ярихад бол 12 сард хамгийн сүүлчийн алтуудаа тушаагаад тодорхой хэмжээний бага шиг хэмжээний алтыг бол бас одоо дараагийн алт гартал 3 сар хүртэл ч юм уу эхний алт гартлаа бол тодорхой хэмжээний хадгалж л байдаг. Энэ дээр бол 1 сард тушаадаг, 2 сард тушаадаг алт бол олборлосон биш, тэр бол үндсэндээ 12 сарын л одоо сүүлчийн алтнууд байдаг. Түүн дээрээ нэг их онцын юм бол гардаггүй юм аа. Тийм учраас бол үүнийг бол бас тэр юутайгаа л уялдуулаад оруулаад ирчихсэн нь зүгээр.

Үүгээр бол ерөөсөө бүр ямар нэгэн тийм өмнө бол яасан тохиолдол ерөөсөө байдаггүй, байхгүй, тийм тийм. Тэгэхээр тийм юм бол өөр бол би байхгүй гэж бодож байгаа.

Ч.Хүрэлбаатар: Яах вэ, энэ нэг жил энэ жил аваад алт үлдэгдэл яавал түүнийгээ дараа жилийнхээ юу хурааж авсан, олборлосон алт гээд л мэдүүлж өгөөд л яваад байдаг учраас энэ нэг хариуцлага хэрэгждэггүй байсан. Одоо алт авчраад тушаахаар үгүй ээ наадах чинь хаанаас авсан юм гээд асууна, хэмжээ нь их учраас. Тэгэхээр яах вэ, урьд жилүүдийн алт байсан юм аа гэж одоо хэлсэн ч түүнийг нь нээж өгөөд л явуулж байгаа заалт юм байна гэж ойлгосон. Зүгээр энэ аливаа гэдэг нь ямар нэгэн одоо хариуцлага хүлээлгэхгүй ээ, та нар алтаа тушаагаач ээ л гэж. Хуулийн заалттай

Г.Ёндон: Татвартай ч холбоотой гэдэг юм уу, ингээд л нэг ийм л юм байж байгаа

Ч.Хүрэлбаатар: Тэгэхгүйгээр цаана нь хар аа, Булгантуяа бид нар бас түүн дээр ажлын хэсэг дээр ярьсан. Зарим хариуцлагыг нь чөлөөлөөд, заримыг нь чөлөөлөхгүй гээд хэлчихвэл хүмүүс тушаахгүй байхгүй юу. Нэгэнт л 5 хувь амлаад л одоо алтаа дотооддоо байгаа алтуудаа хамж явъя гэж байгаа бол бүх төрлийн хариуцлагаас чөлөөлчих хэрэгтэй юм байгаа юм. Тэгж байгаад алтаа цуглуулж болно. Тэгэхгүй болбол бүр үр дүн хүрэхгүй. Нэг талдаа их чөлөөлөөд байгаа юм шиг мөртөө ганцхан заалтаар бүх юмаа үгүйсгэчихэж магадгүй учраас энэ Засгийн газрын оруулж ирсэн энэ хэлбэрээрээ байх нь зөв өө л гэж одоо үзэж байгаа юм.

Хуулийн төслийн 10 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Байхгүй.

Хуулийн төслийн 11 дүгээр зүйлтэй холбогдуулан асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Байхгүй.

Санал дууслаа.

Одоо хамт өргөн мэдүүлсэн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж эхэлье.

Хуулийн төсөл нь 3 зүйлтэй. Энэ дээр би асуулт асуучихъя. Энэ ажлын хэсгийнхнийхээ өмнөөс ч би жоохон өөрөө ярьчихсан юм.

Орос бол банкнуудад одоо төлбөр шилжүүлэхэд түвэгтэй. Тэгэхээр ер нь арилжаа наймаа тийшээ бол Монголчууд бол нэлээд одоо доллар ч юм уу, рубль ч юм уу ийм юм авч гарч хийх хэрэгтэй болчихоод байгаа юм. Гэтэл үүнийг нь 6000 доллароор хязгаарлачихаар бизнес эрхлэхэд түвэгтэй байдал үүсгээд Монголд орж ирэх одоо янз бүрийн бараануудыг одоо хомсдол бий болгох, нийлүүлэлт тасрах, эсвэл одоо бизнес хийхэд нэг гараад оруулаад ирэх юмыг 2 гардаг ч юм уу ийм байдал руу оруулаад яг өнөөгийн цаг нөхцөл байдалд ийм хэцүү байхад бизнес эрхлэгч нартаа илүү дарамт учруулчих юм биш биз дээ. Тэгээд бусад орон руу 10 мянган доллар оруулах нь зөвшөөрөлтэй байгаа юм чинь үүн дээр тэгж нэг их төвөг учруулаад хэрэг байна уу, үгүй юу. Тэр тусмаа Монголбанкны Ерөнхийлөгч бол нийт доллароор хийгддэг гүйлгээнийх нь бол 2 хувь нь л одоо гадуур байдаг гэж хэлсэн шүү дээ. Бусад нь бүгд банкаар явчихдаг. Тэгэхээр хоёрхон хувь дээр хэдүүлээ ингэж байж, угаасаа хомсдолыг улам нэмэгдүүлээд бизнес эрхлэгчдийнхээ бухимдлыг нэмчих юм биш биз дээ. Зүгээр энэ нөгөө энэ жилдээ ер нь ингэж өөрчилж, хэмжээг нь ингэж өөрөөр оруулж ирэх шаардлага байна уу, үгүй юу.

Жавхлан сайд.

Б.Жавхлан: Тийм, болгоомжилж байгаа санааг нь би ойлгож байна. Тэгэхдээ Хүрэлбаатар дарга аа, нэг ийм судалгаа байгаад байгаа юм аа. Одоо яг таны хэлж байгаагаар одоо яг Сэлэнгийн бүс дээр хилийн ойролцоо, яг хилийн арилжаа наймаа хэрэглэдэг үүргийн худалдаачдын тийм хүмүүсийн нэг удаа авч гардаг бэлэн мөнгөнийх нь тоо нь бол дунджаар энэ 20 сая төгрөг хүртэлх нь болбол нийт авч гарч байгаа тоон ширхгийн хувьд бол бараг 90 гаруй хувь нь байгаа байхгүй юу. Сая 02 сарын 24-өөс хойш ямар тохиолдол гарсан бэ гэхээр, онгоцоор нэг удаа сая гаран доллар гарсан байгаа. 10 хүнд ингээд хуваагаад 100, 100 мянган доллар хувааж өгөөд диклярац дээрээ бичээд, ингээд хил гарч яваад цаанаа ингээд хураагаад аваад явчихсан. Энэ бол сая доллароор очоод одоо үүргийн худалдаа ганзагын наймаа хийх гэж байгаа зүйл бол биш. Энэ болбол богино хугацаанд Оросод доллар рублийн савлагаа үүссэн иймэрхүү байдалтай уялдуулж богино хугацаанд ийм арбитр хийх зорилготой иймэрхүү манайхаас гадагшилсан ийм валютын урсгал гэж харж байгаа юм.

Тэгэхээр яг энэ үүргийн худалдааныханд бол худалдаачдадаа бол одоо нэг их дарамт учраад, тоог нь хязгаарлачихсан гэж судалгаагаар бол нэг тийм юм гарахгүй ээ. Зүгээр яах вэ, ингэж болохгүй юу 20 саяыг нь нэмээд 30 сая, 40 сая байж болно

шүү дээ. Тэгэхээр болбол яг үүргийн худалдаачдын хувьд болбол би хангалттай гэж харж байна.

Яг богино хугацаанд ашиг олох зорилготойгоор яг гадагшилж байгаа валютын урсгал дээр тэр том дүнтэй юмнуудыг бид нар яг одоо бол хязгаарлахаас өөр арга байхгүй. Гадагшаагаа төлбөр хийгдэх юм уу, бид нар хязгаартай ч гэсэн бол хийж байгаа шүү дээ. Хязгаартаа ч гэсэн хийж байгаа, ямар ч байсан. Тийм учраас үүнийг тоон дээр нь эргэж хараад одоо яг хилийн худалдаан дээр нь бол иргэддээ өшөө боломжийг нь тавьж өгөөд, тийм том дүнтэй дүнгүүдийг болбол гадагшлахыг нь хориглох нь зөв байх аа гэж бодож байна аа.

Ч.Хүрэлбаатар: Тэгэхээр 20-ыгоо 10 мянган доллартой тэнцэхүйц хэмжээнд нь л тийм ээ. Жишээлбэл Орос чинь 10 шүү дээ тийм ээ. Тэгэхээр 100 гээд ороод ирэхээр чинь 90 нь илүү гээд л хураахаас өөр аргагүй шүү дээ. 90-ээ хураалгана. Тэгэхээр бусад оронтой байж байгаа юман дээр хэдүүлээ өөрсдийнхөө иргэддээ, бизнес эрхлэгчдэдээ тийм хүндрүүлсэн хориглосон заалт байх. Тэгвэл 10 мянган доллартой тэнцэхүйц хэмжээний валют, төгрөг гээд л биччихье л дээ, тэгэх үү.

Тэгвэл энэ нь хууль нь байг, ажлын хэсэг дэргэд бол байг, 20 сая гэдгээ одоо цаашаа орох хэмжээгээр нь л 10 мянган доллартой тэнцэхүйц хэмжээ гэдгээр нь явчихна байна шүү дээ.

Миний асуулт бол ингээд дуусчихлаа.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Байхгүй.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Байхгүй ээ.

Хамт өргөн мэдүүлсэн тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье ээ.

Энэ бол Засгийн газар нэг 3 төрлийн бүтээгдэхүүн дээр импортын татварыг зохицуулах эрхийг авъя гэж байгаа юм байна лээ. Энэ нь яг энэ нефть бензинтэй эрчим хүч, цахилгаантай холбоотой ийм юм байна лээ. Үүнийг бол ажлын хэсэг бол дэмжээд л явж байгаа.

Энэ тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна аа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Байхгүй байна аа.

Хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлэг хийсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд Их Хурлын гишүүн би өөрөө байдаг юм чинь Хүрэлбаатар танилцуулна аа.

Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр, төрлийн бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Баярлалаа.

Өнөөдрийн хуралдаан дууссаныг мэдэгдье.

Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА